



МОНГОЛ-ЯПОНЫ ТӨВИЙН ЯПОН ДАХЬ ДАДЛАГА СУРГАЛТЫН ТАЙЛАН

2025.03.02-03.15

Улаанбаатар хот
2025 он

ГАРЧИГ

1. Сургалтын талаарх товч танилцуулга
2. Бизнесийн үндсэн сургалтын төгсөгч
 - 1) Б.АЛТАНШАГАЙ
 - 2) Н.БАТЗАЯА
 - 3) Х.БАТХИШИГ
 - 4) Б.БУМАНЦЭЦЭГ
 - 5) Б.ЖАВХЛАНТ-ОД
 - 6) В.ЗОРИГТ
 - 7) Ё.МӨНХЗАЯА
 - 8) Б.ОТГОНЦЭЦЭГ
 - 9) Б.САНЧИР
 - 10) Б.САРНАЙ
 - 11) О.УЯНСАЙН
 - 12) А.ЧИМЭДЦЭРЭН
 - 13) Н.ЭНХЖАРГАЛ
 - 14) М.ЭНХМАНДАХ
 - 15) Ц.ЭНХТУУЛ
 - 16) Э.ЭНХЦЭЦЭГ
 - 17) М.ЭРДЭНЭ-ОЮУН
 - 18) О.ЭРХЭМБАЯР
3. Үндэсний сургагч багш
 - 19) Б.ДАВААСҮРЭН
4. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, ЖДҮ-н газрын мэргэжилтэн
 - 20) Б.БАТБОЛД
5. Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн мэргэжилтэн
 - 21) Н.БАТДЭЛГЭР
 - 22) Э.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Япон дахь дадлага сургалтын талаарх товч танилцуулга

Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд 2002 оноос эхлэн Бизнесийн үндсэн сургалтыг 23 дахь жилдээ зохион байгуулж байна. Тус сургалтад 2025 оныг хүртэл давхардсан тоогоор нийт 1120 гаруй жижиг дунд аж ахуй нэгжийн удирдлага болон менежер суралцаж төгссөн.

Бизнес сургалтын төгсөгчдийн туршлагаас харахад сургалтаар сурсан зүйлээ бодитоор хэрэгжүүлэхээр хичээл зүтгэл гарган ажиллаж байгаа боловч, төдийлөн үр дүнд хүрч чадахгүй байх нь олонтой учир Япон маягийн менежментийн хэрэгжүүлэлтийг Японы компаниудын бодит байдлыг харж, сонсож суралцах нь илүү үр дүнтэй хэмээн энэхүү дадлага сургалтыг санаачлан зохион байгуулж эхэлсэн билээ. Бизнес эрхлэгчдэд Япон компаниудын бодит байдалтай биечлэн танилцаж, бид ямар түвшнийг зорих ёстой вэ гэдэг загвар жишгийг нүдээр харж мэдрэн, туршлагаас нь суралцсанаар компаниудын үр ашигтай зохион байгуулалт шийдвэр гаргалтад нөлөөлж, улмаар энэ нь бизнес сургалтын үр дүн жинхэнэ утгаар хэрэгжиж, Монголын жижиг дунд бизнес цэцэглэн хөгжихөд дорвитой хувь нэмэр болно гэж үзэж байгаа юм.

Энэхүү сургалтаар дамжуулан олж авсан мэдлэг туршлагаа үр дүнтэй ашиглах талаар ажлын төлөвлөгөөг заавал боловсруулах бөгөөд сургалтын дараа ажлын төлөвлөгөөгөө бусадтай хуваалцах зорилгоор энэхүү тайланг бэлтгэн дараа дараагийн суралцагчдадаа танилцуулж байна.

Энэ удаагийн сургалт дараах агуулгаар явагдаж дууслаа.

1) Сургалтын талаарх товч танилцуулга

Сургалтын нэр: Бизнесийн үндсэн сургалт төгсөгчид болон
Үндэсний сургагч багш нарын Япон дахь дадлага сургалт

Сургалтын хугацаа: 2025.03.02 (Ням) - 03.15 (Бямба) 2 долоо хоног

Сургалтын зорилго, агуулга:

Япон маягийн менежментийг ойлгох, өөрийн компанийн бизнесийг сайжруулах, хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг авч үзэх.

1. Өөрийн компанийн менежментийн асуудлаа тодорхойлох
2. Японы компанид бодитоор айлчлан удирдах албан тушаалтантай санал бодлоо солилцож, бизнесийн сургалтаас сурч мэдсэн Япон маягийн менежментийн талаарх ойлголтоо гүнзгийрүүлэх.
3. Бизнесийн сургалт болон Япон дахь дадлага сургалтаас олж авсан мэдлэгээ өөрийн компанийн бизнесийн сайжруулалт, хөгжүүлэлтэд үр дүнтэй ашиглахын тулд үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргах
4. Япон төвийн оролцогч тал (ажилтнууд гэх мэт) ямар хүний нөөцийг хөгжүүлэх хүсэлтэй байна вэ гэх мэт, Япон дахь дадлага сургалтаар олж авсан мэдлэг дээрээ тулгуурлан Япон төвийн ажилтнуудад хувь нэмэр оруулж, Япон төв дахь бизнесийн сургалтын менежментэд үр дүнтэй ашиглах.

Нэр: Б.Алтаншагай

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2017

Анги: Удирдлагын анги



Ажиллаж буй байгууллагын нэр	“ХАНГЭ” ХХК
Албан тушаал	Дэд захирал
Байгуулагдсан он	2016
Үйл ажиллагааны чиглэл	Худалдаа, үйлдвэрлэл
Нийт ажилтны тоо	41
Компанийн товч танилцуулга	
Манай компани нь 2016 онд гадаад худалдаа, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр байгуулагдсан бөгөөд ОХУ, БНХАУ-аас сайн чанарын 1-р зэрэглэлийн гахай, тахианы мах импортоор оруулж ирж бөөний болон жижиглэн худалдааны төвүүд, мах махан бүтээгдэхүүн хийдэг үйлдвэрүүдэд нийлүүлж байна. Мөн бид тахианы махаар хагас боловсруулсан бүтээгдэхүүн хийж хэрэглэгчдийг чанар стандартын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнээр хангаж байна.	
1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго	
Бид үйлдвэрлэлээ өргөжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд олон улсын стандарт, импорт, экспортын боломжийг судлах, өөр нэр төрлийн бүтээгдэхүүн, түүнийг үйлдвэрлэх тоног төхөөрөмж судлах зорилготой.	
2. Суралцсан зүйл	
Япон бизнесийн философи: энгийн, тогтвортой, алсын хараатай үйл ажиллагаа Удирдагчийн хандлага, санаачлагчид, зай талбайг бүрэн ашиглах, чанар, сав баглаа боодол зэрэг.	
3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө	
- Туркийн RDM компанитай тахианы мах импортлох талаар санал солилцсон, энэхүү хэлэлцээрийн талаар дэлгэрэнгүй судлах, хэрэгжүүлэх. - Олон улсын үзэсгэлэн яармагт оролцоход бүүтийн тохижилт сайжруулах, бүүт дээр ажиллаж буй борлуулагчдыг сургах.	

3. Компанийн удирдлага нь соёл үнэт зүйл, алсын хараа, зорилгоо нийт ажилчдадаа сайн таниулан ойлгуулах.

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

Үйлдвэрийн шинэ өргөтгөлийг зочид хэрэглэгчдэд нээлттэй үзүүлэн байдлаар тохижуулах.

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

1. Фүүдэкс үзэсгэлэнд оролцогчдын захирлууд болон эзэд буюу шийдвэр гаргах хүмүүс нь ирэх хэрэгтэй санагдлаа.
2. Бүүтийн дэргэд сууж уулзах талбай нь нээлттэй, том баймаар байна.
3. Хүмүүс нь бүүтийнхээ ард биш урд талбайгаар амталгааны бүтээгдэхүүнээ бариад хүмүүст хүргэвэл илүү үр дүнтэй санагдлаа.
4. Компанийн удирдлага нь соёл үнэт зүйл, алсын хараа, зорилгоо ажилчдадаа сайн таниулж ойлгуулснаар бүгд нэг үзэл санаа зорилготойгоор эрчимтэй урагшлах болно.

Нэр: **Н.Батзаяа**

Үндсэн сургалтад хамрагдсан он: **2019**

Анги: **Удирдлагын анги**



Ажиллаж буй байгууллагын нэр	Витафит групп, “Оргил хүнс” ХХК
Албан тушаал	Гүйцэтгэх захирал
Байгуулагдсан он	2009
Үйл ажиллагааны чиглэл	Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл
Нийт ажилтны тоо	50

Компанийн товч танилцуулга

“Оргил Хүнс”ХХК нь “Витафит” группийн хөрөнгө оруулалтаар 2009 онд сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр байгуулагдсан.

“Тоё”, “Гэр”, “Пороро” нэрийн төрөл бүрийн тараг үйлдвэрлэдэг. Үйлдвэрлэлийн гол түүхий эд болох үнээний шингэн сүүгээ Төв аймгийн Бор нуур, Зүүн хараа, Батсүмбэр сумдаас “Витафит милк” компанийн сүү бэлтгэлийн албаар дамжуулан бэлтгэдэг.

Монгол улсын хот, хөдөө орон нутгийн 6,000 гаруй харилцагчаар дамжин хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ хүргэдэг.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чанарын тогтолцоо, бүтээгдэхүүний чанарын тогтолцоог үйлдвэрлэлд нэвтрүүлсэн.

1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

-Япон маягийн менежментээс суралцах.

-Япон үйлдвэртэй танилцаж, туршлага судлах. Эргэж ирээд нэвтрүүлэх боломжтой санаа олж авах.

-Foodex-2025 үзэсгэлэнгээс ирээдүйд хамтран ажиллах боломжтой компанитай холбоо тогтоох

2. Суралцсан зүйл

Хувь хүний хувьд:

-Бусдад төвөг удахгүй байх, цэвэрч байдал, цаг баримтлах, дүрэм журам ягштал баримтлах, бусдыг хүндлэх.

Танилцсан Япон компанийн хувьд:

-Манай компанитай ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг сүүний үйлдвэртэй танилцах завшаан тохиолоо. Сургалтын танхим болон танилцуулах коридорыг хүүхдэд зориулсан сүү үйлдвэрлэлтэй холбоотой танин мэдэхүйн үзүүлэн самбаруудаар тохижуулсан нь сонирхолтой байлаа.

-Өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ үнэ цэнийг ажилтан бүр мэддэг байх. Өөдрөг үзлээр хариуцсан ажилдаа хандах.

-Ямар ч үйлчилгээ нь аль болох үйлчлүүлэгчид төвөггүй байхаар бодож шийдвэрлэх.

-Хүний хөдөлмөр хөнгөвчлөх тал дээр гаргасан ажилтнуудынхаа шинэлэг санааг бага гэлтгүй дэмжин урамшуулж, хэрэгжүүлэх.

Foodex үзэсгэлэнгийн хувьд:

Томоохон хэмжээний Үзэсгэлэнд оролцохдоо урьдчилан төлөвлөж тооцсон байх. Хэрэггүй зүйлд цаг алдахгүй байх. Хэрхэн харилцагчийн анхаарал татах.

Эшлэл:

1. Сүүний үйлдвэрлэлийн процессыг хэрэглэгчдэд танилцуулж эхлэхдээ хэлэх үг “Хэрхэн үнээний сүүг хүн уудаг сүү болгодог вэ?”
2. “Үйлдвэрээс гарсан гологдол бол Осол”

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

“Витафит” группийн шинэ бүтээн байгуулалтын төсөлд өөрийн суралцсан зүйлээс тусгаж хэрэгжүүлэх:

-Хүнсний үйлдвэрийн барилга барихдаа анхнаас нь хэрэглэгчдэд үйлдвэрээ танилцуулах зорилго давхар агуулж, танилцуулах танхим, үйлдвэрийн дотор нэвтрэлгүйгээр гаднаас нь танилцах цонх бүхий коридор төлөвлөх.

-Тэдгээрийн дотоод тохижилтыг төлөвлөхдөө Японд зочилсон сүүний үйлдвэрийн тохижилтын санаанаас тусгах.

Foodex-2025 үзэсгэлэнд оролцсон Беларус компаниас түүхий эд худалдан авахаар холбоо тогтоосон ба Худалдааны гэрээ байгуулах

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

Ажилтнуудын дунд бүтээмж дээшлүүлэх, хөдөлмөр хөнгөвчлөх шинэ санааны Хөтөлбөр боловсруулж нэвтрүүлэх.

“Үйлдвэрээс гарсан гологдол бүтээгдэхүүн бол Осол” гэсэн үзэл баримтлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх.

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Дадлага сургалтын үеэр очих компани болон орох сургалттай холбоотой урьдчилж тараагдсан материалуудтай сайтар танилцсан байх хэрэгтэй. Ингэснээр үнэ цэнтэй олдож байгаа дадлага сургалтаас их зүйлийг олж авахад нэмэртэй. Сургалт, танилцуулгын үеэр тэмдэглэл хөтөлж, дараа нь асуулт хариултын үеэр оновчтой цомхон байдлаар асуулт тавьж хариулт авах нь үр дүнтэй.

-Бусад оролцогчдоо хүндэлж, боломж олгох хэрэгтэй.

-Аль болох урьдчилж тараагдсан материал дээрх мэдээлэлтэй давхцаж асуухгүй байх.

-Мөн цаг нөхцөөсөн, илэрхий зүйл асуухаас зайлсхийх хэрэгтэй.

Хэдийгээр үнэгүй ч хоолыг хүртэл өөрийн хэрэгцээнээс хэтрүүлэлгүй сонгох нь зүйтэй. Энэ нь уг хоолыг хийсэн хүний хөдөлмөрийг хүндэтгэхээс гадна таны хандлага ч харагдана.

За тэгээд усыг нь уувал ёсыг нь дага гэдэг дээ.

Дараагийн азтанд амжилт хүсье.

Нэр: Х.Батхишиг**Үндсэн сургалтад хамрагдсан он:** 2017-2018**Анги:** Удирдлагын анги

Ажиллаж буй байгууллагын нэр	“Мон-Интра” ХХК
Албан тушаал	Маркетингийн ерөнхий зөвлөх, менежер
Байгуулагдсан он	1998
Үйл ажиллагааны чиглэл	Эмийн сан, эмийн үйлдвэрлэл, эм ханган нийлүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.
Нийт ажилтны тоо	20

Компанийн товч танилцуулга

“Мон-Интра” ХХК нь 1998 онд анх гадаад, дотоод худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үүсгэн байгуулагдсан.

- Эмийн сан, эмийн үйлдвэрлэл, эм ханган нийлүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.
- 2011 оноос эхлэн уламжлалт эмийн үйлдвэр байгуулах төслийг эхлүүлж, 3,8 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.
- 2018 онд уламжлалт эмийн үйлдвэр болон өргөжсөн.
- 2022 онд “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал” (GMP)-ын шаардлага хангасан Монгол Улсын анхны уламжлалт эмийн үйлдвэр болсон.
- Монголын уламжлалт 100 хувийн байгалийн гаралтай эм, танг үйлдвэрлэн дотоод болон Европын зах зээлд нийлүүлэгч үндэсний үйлдвэрлэгч компани.
- Эмийн үйлдвэр нь 25 гаруй ажилтантай.
- Мон-Интра Уламжлалт эмийн үйлдвэр нь 200 гаруй түүхий эдээр 122 төрлийн эмийг, 3 хэлбэрээр үйлдвэрлэж байна.
- Түүхий эдийг дотоод (байгаль дээрээс түүх болон түүхийн эдийн тарималжуулах талбай) болон гадаадаас татан авдаг.

1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

Ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг компани, тэдгээрийн үйлдвэрлэж буй эрүүл мэндийг дэмжих болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, маркетинг, үйл ажиллагаа, сав баглаа боодол, тоног төхөөрөмж зэргийг судлах.

Шинэ санаа олох, харилцаа холбоо тогтоох, хөтөлбөрийн бүр үйл ажиллагаанд идэвх санаачилгатай ажиллах.

Япон улсаас хүнсний нэмэлт болон эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг импортлох богино хугацааны зорилтой бол өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг Япон Улсад экспортлох урт хугацааны зорилготой.

2. Суралцсан зүйл

Компанийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийг дахин шинэчлэх, компанийн үйл ажиллагааг 100 жилээр тодорхойлохыг.

Үүсгэн байгуулагч, гүйцэтгэх удирдлагаас эхлэн нэгж ажилтан хүртэл зорилго, зорилт, үйл ажиллагааг тодорхой болгож, нэг түвшинд харилцан ойлголцлыг бий болгохыг, Эерэг сэтгэл шингээсэн бүтээгдэхүүн хийхэд бүх анхаарлаа хандуулахыг, Япон бизнесийн философи, менежмент, чанарын удирдлага, 5S, 5 яагаад гэх мэт зүйлсийг компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэх арга замыг тус тус сурсан.

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

1. Компанийн алсын хараа, эрх зорилго, үнэт зүйлсийг энэ онд багтаан шинэчлэх
2. Шинжилгээ, судалгаа хийх лабораторийг энэ онд багтаан сайжруулах.
3. 5S-ийн зарчмыг 2-р улирлаас эхлүүлэн нэвтрүүлэх.
4. Чанарын удирдлагыг хагас жилээс өмнө судалж, нэвтрүүлж эхлэх.

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

1. Хувь хүний хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах, сургалтын үйл ажиллагааг явуулах,
2. Ажилчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, шинэ санааны урамшууллын системийг бий болгох
3. Бүтээгдэхүүнийг хэрэглэх шинэ арга хэлбэрийг судлах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх
4. Бүтээгдэхүүн, үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах, арга замыг бий болгох,
5. Бүтээгдэхүүнийг хийж байгаа процессыг хүүхдэд ойлгомжтой, энгийн байдлаар үзүүлсэн контент, үзвэр үйлчилгээг нэвтрүүлэх.
6. Компанийн брэнд, маркетинг, санхүү, хүний нөөцийн бодлогыг сайжруулах.

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Дадлага сургалтад хамрагдахаас өмнө бэлтгэл ажлыг маш сайн хангах. Үүнд:

- Үндсэн хичээлээ сэргээн үзэх, санах,
- Үндсэн хичээлээс сурсан зүйлсээ компани дээрээ хэрэгжүүлсэн туршлагатай байх,
- Чиглүүлэх сургалтыг маш анхааралтай сонсож, тэмдэглэнэ авах,
- Эргэлзээтэй зүйлээ тодруулж сайн асуух
- Сургалтад хамрагдах зорилго, зорилтоо тодорхойлж, түүний дагуу төлөвлөгөө боловсруулах,
- В төлөвлөгөөтэй байх,
- Цаг тулгахгүй эртнээс бэлтгэлтэй ажиллах

Дадлага сургалтад очсон үед анхаарах зүйлс:

- Багшаас өгч буй зааварчилгаанаас зөрөхгүй байх
- Цагийг яг таг баримтлах
- Хөтөлбөр болон тараах материалтай өдөр бүр уншиж танилцах,
- Оройн тухай өдөрт хийсэн ажлаа дүгнэж, өөрийн төлөвлөгөөний дагуу явж байгаа эсэхээ хянаж байх

Нэр: **Б.Буманцэцэг**Үндсэн сургалтад хамрагдсан он: **2023**Анги: **Удирдлагын анги**

Ажиллаж буй байгууллагын нэр	Даймонд Стар ХХК
Албан тушаал	Захирал
Байгуулагдсан он	2018
Үйл ажиллагааны чиглэл	Гадаад импорт худалдаа
Нийт ажилтны тоо	5-10
Компанийн товч танилцуулга	
Даймонд Стар ХХК /6266711/ нь 2018 оноос гадаад худалдаа, аялал жуулчлал үйлчилгээний чиглэлээр River Garden-River Street “Алтай Таван Богд” уул, аяллын хувцас, тоног хэрэгслийн дэлгүүрийг ажиллуулж байна. Манай компани Дэлхийд танигдсан олон улсын хэрэглэгчдийн стандарт, аюулгүй байдлын шаардлагуудыг хангасан доорх брэндүүдийн Монгол улс дахь албан ёсны дистрибьютерээр ажиллаж байна. - Италийн Climbing Technology - Ууланд авиралтын хамгаалалтын тоног хэрэгсэл - Италийн CAMP - Ууланд авиралтын хамгаалалтын тоног хэрэгсэл - Италийн Kayland - Ууланд авиралт, алхалтын гутал - Италийн Salewa - Уулын гутал, хувцас, хэрэгсэл - Италийн Dynafit - Цана, дугуй, гүйлтийн (гутал, хувцас, хэрэгсэл) - Шведийн Thule - Бүх төрлийн цүнх, чемодан, авто машины ачаа - Шведийн Wildo - Аяллын аяга тавгийн сет - Шведийн Morakniv - Бүх төрлийн хутга - Польшийн Helikon-Tex - Тактикийн хувцас, хэрэгсэл - Испани Buff - Бүх төрлийн хүзүүвч, малгай - Английн Ridge gear - Бүх төрлийн хамгаалалтын хэрэгсэл - Английн Wild Country - Хад, хананд авиралтын хэрэгсэл, хувцас - Америкийн Evolv - Хад, хананд авиралтын гутал - Америкийн Case Logic - Камерын цүнх, нөтбүүк-ний цүнх/гэр	

Манай компанийн уул, аяллын хувцас, тоног хэрэгслийн төрөлжсөн интернэт худалдааны цахим хуудса болох www.altaitavanbogd.com-аас брэндүүдийн танилцуулга болон зураг, үнэ харах боломжтой.

1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

Манай компани шинэ зах зээл рүү тэлэх зорилготойгоор Япон дахь дадлага сургалтад хамрагдаж Diamond Star Foods гэж салбарлах гэж байгаа. Ж/нь:

1. Кофе шоп /Уул аяллын болон хөдөлгөөнт амьдралыг илүүд үздэг гүйх дуртай, цана, дугуй гэх мэт аялагчдад зориулж нээх хүсэлтэй байгаа/
2. Аяллын хуурай болон хөлдөөсөн хүнс
3. Шингэн хүнс гэх мэт

2. Суралцсан зүйл

1. Цаг баримтлал: Бүх юм яг цагтаа эхэлж цагтаа дуусаж байсан. Заримдаа цагтай уралддаг тэмцээнд орж байгаа мэт санагдаж билээ. /ккк/
2. Эмх цэгц: Бүх юм ойлгомжтой, цаг алдаж будилах шаардлагагүй
3. Тууштай байдал: Компани болон үйлдвэрүүдтэй танилцахад олон жилийн түүхтэй үе дамжсан бизнесүүд байсан. Ж/нь Уламжлалт аргаар цуу үйлдвэрлэдэг компани 300 гаруй жилийн өмнө анх үйл ажиллагаа явуулж эхэлсэн 12 дахь өв залгамжлагч нь орчин цагтай уялдуулаад одоогийн нийгэмд ч хоцролгүй хөл нийлүүлэн өрсөлдөж Экспорт хийдэг мөн ресторан, кекс, чихэр, зайрмаг гэх мэт салбар бизнес болгон өргөжүүлсэн байсан.
4. Цэвэр байх: Бүх очсон Компани болон үйлдвэрүүд маш цэвэрхэн байсан. Нэг захирлын яриагаар аз гэж байдаг тэр нь цэвэрч байдлаас эхлэлтэй. Өдөр бүр 00-оо 4 удаа угаадаг гэж хэлж билээ.
5. Дизайн: Маш гайхалтай интерьер тохижилт. Санаа авч дэлгүүр дээрээ хэрэгжүүлэхээр олон зүйлс их байсан. Санхүү нь байдаг бол тохижилтыг нь дуурайгаад тултал хиймээр санагдсан.

Маш олон зүйлс суралцсан.

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

1. Зорилгоо тодорхой болгох
2. Эмх цэгц цэвэр байдлыг хэвшүүлэх
3. Цаг баримтлал, цаг зарцуулалт тодорхой болгох
4. Хийхгүй зүйлсээ гаргаж бичих
5. 5с хэрэгжүүлнэ.
6. ХН өө зөв хуваарилах
7. Орчин цагтай хөл нийлүүлэн мэдээллээс хоцрохгүй байх

8. Уурлахгүй байж өмнөх сайхан харилцаагаа сэвтээхгүй байх
9. Инээмсэглэх
10. Үргэлж сайхан харилцаатай байхыг хичээх

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

1. Компани: Foodex-25 миний санаснаас илүү үр өгөөжөө өгсөн. Би нийт 20 гаруй айлтай уулзалдаж нэрийн хуудсаа солилцсон. Итали, Швед, Израйл, Индонез, Тайван, Египет, Япон гэх мэт уулсуудтай нэг дор уулзаж цаг хугацаа, санхүү мөнгө хэмнэсэндээ баяртай байна. Энэ экспод оролцсоноор маш олон айлуудтай майл ээр холбогдож үнийн санал ирсэн байгаа.

Удахгүй хүсэн хүлээсэн Кофе шоп оо нээнэ. Одоогоор Итали-5 айл майл бичсэн байсан. Үүнд: Кофе болон кофены машин төхөөрөмж, Протейн, Хөлдөөсөн Итали пицца, Шингэн хүнс гэх мэт айлуудтай хамтарч ажиллахаар төлөвлөж байна.

2. Хувь хүн: Би Англи хэлийг илүү сайжруулахыг хүссэн. Мөн ОУ-н экспод санхүү болон цаг гаргаж оролцож байхаар шийдсэн. Үргэлж суралцаар өөрийгөө хөгжүүлж улс эх орондоо ажлын байр нэмэгдүүлж үлгэр жишээ Компани бий болгохыг хувь хүнийхээ талаас хүсэж байна.

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

1. Юуны тулд суралцаж байгаагаа тодорхойлох
2. Экспо-д оролцох гэж байгаа бол стратегитай оролцох. Дэлгүүр хэсэхдээ ч стратегитай цагийн менежменттэй байж зөв зарцуулах
3. Англи хэлийнхээ түвшинг үргэлж сайжруулж байх
4. Илүү дутуу хүнд өмсөхгүй олон хувцас авч явахгүй байх
5. Яг тэр чигээр нь биш ч гэсэн Монголд яаж хэрэгжүүлж болох уу? Хэмээн бүх явсан газраасаа санаа авч тэмдэглэж явах.
6. Экспо-д оролцохдоо би жижиг тэмдэглэлийн дэвтэр бал 2 той явсан. Нэрийн хуудсан дээр 1,2,3 гэх мэт тоо бичээд тэмдэглэлийн дэвтрэн дээрээ мөн ижил тоогоо бичиж тухайн үед уулзсан хүмүүсийн мэдээлэл юу ярьсан талаар бичиж авсан.
7. Цүнхээ хөнгөн илүү юм хийлгүй авч яван мэдээлэл цуглуулсан танилцуулга нэрийн хуудсаа хийх.
8. Нэрийн хуудсаа Англи Япон хэл дээр авч явах
9. Бүх 00 ус татагч нь өөр өөр газар байдаг тул орохдоо анзаарч эхлээд олж хараад мэдчихвэл зүгээр санагдсан. /ккк/
10. Хичээлийн дараа юу үзэхээ тодорхой болгох

Нэр: Б.Жавхлант-Од

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2024

Анги: Удирдлагын анги



Ажиллаж буй байгууллагын нэр	Мөнх Амтшил ХХК
Албан тушаал	Гүйцэтгэх захирал
Байгуулагдсан он	2021
Үйл ажиллагааны чиглэл	Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, Дистрибюшн
Нийт ажилтны тоо	24
Компанийн товч танилцуулга	
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, түгээлт, худалдааны чиглэлийн компани. Хүнсний бүтээгдэхүүн дээр голчлон ажилладаг. Вендинг машин хөгжүүлэгч	
1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго	
1. Хамтралын ферм судлах 2. Distribution төвөөр зочлох 3. Vending машин 4. FoodEx expo зочлох 5. Nabel компаниар зочлох 6. Хуурай өндөгний судалгаа 7. Майонез судалгаа 8. Жигнэмэг үйлдвэрлэл судалгаа	
2. Суралцсан зүйл	
Философийн хүрээнд: 1. Үйл ажиллагааг аль болох энгийн, тогтвортой байлгах. Зорилгоо хол том тавих 2. Жижиг хэсгийг ч орхилгүй хөгжүүлэх 3. Удирдагчийн хандлага маш чухал. Байнга баярлалаа гэж хэл 4. Ажилчид бол санаачлагчид. Тэдний санаачилгыг дэмжин ажилла 5. Хүнс хийж байгаа бол инээ Санаа аван хэрэгжүүлэх:	

1. Үзэмж муу боловч чанар сайн бол зар. Үзэмж сайн боловч чанар муу бол бүү зар
2. Үйлдвэрийн зай талбай бүрийн ашигла
3. Үйлдвэр доторх гологдол бол гологдол. Үйлдвэрээс гарсан гологдол бол ОСОЛ
4. Үйлдвэр Аяллын цэг байж болно.
5. Чанар = Сав баглаа боодол

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

2025 оны 4-5 сард

- Одоо TQC (The Quality Control) хийж байгаагаа TQM (The Quality Managment) болгож сайжруулна.
- “Үйлдвэрээс гарсан гологдол бол осол юм” сэтгэхүйг компанидаа суулгах
- Төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, гүйцэтгэх

2025 ондоо багтан хэрэгжүүлэх

- Өндөгний савлагааг бүрэн шинэчилнэ,
- Шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх (Бидонтой жигнэмэг үйлдвэрлэнэ),
- Өндөглөгч тахианы махны экспорт Турк улс руу хийнэ.
- Vending машины багц гаргана.

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

- Үзэмж муу боловч чанар сайн бол зар. Үзэмж сайн боловч чанар муу бол бүү зар
- Үйлдвэрийн зай талбай бүрийн ашигла
- Үйлдвэр доторх гологдол бол гологдол. Үйлдвэрээс гарсан гологдол бол ОСОЛ
- Үйлдвэр Аяллын цэг байж болно.
- Чанар = Сав баглаа боодол

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Сургалтын үндсэн агуулгаас гадна чөлөөт цагаараа маш их юм үзэх хэрэгтэй. Дэлгүүр бага хэс. Болбол Японы бизнес эрхлэгчидтэй чөлөөт цагаар нь пиво уунгаа уулзаарай. Ажил дээрээ албан байдаг хүмүүс ажлын бус цагаар шал өөр болдог. Аль аль талдаа сурах юм их, хөгжилтэй дурсамж үлдээнэ.

Нэр: Владимир Зоригт

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2024

Анги: Удирдлагын анги



Ажиллаж буй байгууллагын нэр	Хүнс групп ХХК
Албан тушаал	Борлуулалтын газрын захирал
Байгуулагдсан он	1992
Үйл ажиллагааны чиглэл	Үйлдвэрлэл, Худалдаа
Нийт ажилтны тоо	180
Компанийн товч танилцуулга	
1992 онд Сэлэнгэ 9 ХХК нэртэйгээр үйл ажиллагаагаа эхэлж байсан анхны хувийн хэвшлийн нэг бөгөөд 1996 оноос Хүнс комплекс ХХК нэрийг авч мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр ажиллаж эхэлсэн. 2020 оноос менежментийн шинэчлэл хийж дараагийн түвшинд гарах бэлтгэл ажлаа хангасан бөгөөд 2023 оноос Хүнс групп зохион байгуулалтад орж • Хүнс комплекс ХХК • Кайлас ХХК • Чингис рөүд ХХК • Хүнс боловсрол ХХК • Хүнс ферм ХХК гэсэн 5 нэгжтэйгээр ажиллаж байна.	
1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго	
• Ижил төстэй компаниудын ажлын төлөвлөлт, уялдаа, зохион байгуулалтаас суралцах • Өөрийн компанийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд сайжруулах боломжит шинэлэг санаа судлах • Японы компанитай боломжит бүх талаар хамтрах ажиллах • Удирдах арга барилаас суралцах • Бүтээгдэхүүн үйлчилгээг олон жил амжилттай явуулж чаддаг аргачлалд туршлага судлах • Өөрийн компанид шаардлагатай тоног төхөөрөмж судлах	

2. Суралцсан зүйл

1. Орон зай оновчтой ашиглах – Ямар ч бага орон зайг бага гэлтгүй ашиглалт сайтай байж болдог тиймээс зай талбайн ашиглалтыг сайжруулах дээр илүү ухаалаг шийдэл гаргаж байх ёстой.
2. Ойлгомжтой тайлбар - Ямар ч хүн орчинтой харилцах үед шаардлагатай тайлбар зааварчилгаа ямар чухал болохыг бодитоор харсан. Ажлын орчинд заавар зөвлөгөөг оновчтой хийх нь цаг хугацаа хэмнэх бүтээмж дээшлэх үр өгөөжтэй.
3. Бусдын орон зайг хүндэтгэх - Бусдыг хүндэтгэх нь цаашлаад та өөрийгөө хүндлэх харилцааны хувьд төвөгшил үүсэхгүй байх. Ажил үйлчилгээ хурдтай явахад чухал үүрэгтэй.
4. Цаг баримтлах - Цаг баримталж сурах нь цагийн юмыг цагт нь хийх, ажил хурдтай чанартай байхад чухал нөлөөтэй.
5. Бүтээлч байдлыг дэмжих – хариуцсан ажилчдаас ирсэн бүтээлч шинэлэг санааг дэмжсэнээр ажлын орчин ажиллах таатай нөхцөл, асуудлыг хялбар шийдэх, ажлыг хөнгөвчлөх маш олон давуу талтай.

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

1. Ойлгомжтой байдал – бидэнд байдаг боловч ил байдаггүй зүйлсийг нээлттэй болгох, зааварчилгаа зөвлөмжийг байршуулж хэвших.
2. Цаг баримтлах – Бусдыг хүндлэх, ажлын бүтээмжид анхаарах, цагийн юмыг цагт нь хийдэг болох дээр цаг хугацааг хэмжиж сургах.
3. Бүтээлч байдлыг дэмжих – шинэлэг санааг ямагт дэмжиж ажиллах, урамшуулах. Шинэ санал санаачилга гаргаж байгаа ажилтныг дэмжих.
4. Орон зайг бүтээлчээр ашиглах- зай талбайг бага гэж гололгүй ашиглалтын бүх боломжийг харж шийдэх.

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

1. Япон улс руу экспорт хийхэд шаардлагатай сайжруулалт дээр анхаарах
2. Импорт хөгжүүлэлтийг судлах, холбоо тогтоосон компаниудтайгаа дараагийн шатны уулзалт хэлэлцээр хийх.
3. МОЈС төвд жилд 2 удаагийн элсэлтэд ажилтан бүрээ идэвхтэй хамруулах.
4. Суралцаж мэдсэн зүйлсээ ажил хэрэг болгох хэрэгжүүлэх

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

1. Хувь хүний орон зайг их чухалчилдаг улс учраас бусдад төвөг болохгүй байх дээр бүх талаараа анхаарах
2. Худалдаа хийх гэж яаралгүй эхлээд сайн судлах, санхүүгээ зөв удирдах
3. Олон нийтийн газар мөрдөх дүрмийг сайтар анхаарах мэдрэмжтэй байх
4. Тухайн танилцаж байгаа газар болон хүмүүсийн гүйцэтгэл бүтээлч байдал нь юунаас бий болж байгааг нягтлах
5. Цаг баримтлах, товлосон цагаас 10-15 мин өмнө тогтоосон байршилд бэлтгэл байдлаа хангасан байх
6. Компанитай уулзалт хийхээр товлосон бол асуух асуултаа бүх талаас нь судалж бэлдэх.

Нэр: Ё.Мөнхзаяа**Үндсэн сургалтад хамрагдсан он:** 2022**Анги:** Бизнесийн үндсэн сургалт Удирдлагын анги

Ажиллаж буй байгууллагын нэр	Монреимпекс ХХК
Албан тушаал	Ерөнхий менежер
Байгуулагдсан он	1992
Үйл ажиллагааны чиглэл	Оффисын түрээс, кофе шоп, эмийн сан
Нийт ажилтны тоо	20
Компанийн товч танилцуулга	
Монреимпекс” компани нь 1992 онд байгуулагдсан. РЭЭкспорт, гадаад, дотоод худалдаа, үл хөдлөх хөрөнгө, оффисын түрээсийн үйл ажиллагааг эрхлэн явуулдаг үндсэн 35 гаруй ажиллагсадтай. “Монреимпекс” ХХК нь Монгол шуудан банк, Экспорт & Импорт банкйг үүсгэн байгуулагчдын нэг бөгөөд “Монре даатгал” ХХК, “Монре транс”ХХК, “Монре менежмент” ХХК, “Lohao City”ХХК, “Авто хаб” ХХК, “Зээл Шүрэн капитал” ХХК, “Зээл Эм Эн Платформ” ББСБ, “Монре эм импекс” ХХК зэрэг охин компани байгуулсан нь одоо ихэнх нь тус тусдаа биеэ даасан компаниуд болон үйл ажиллагаагаа явуулж байна. Манай компани нь барилгын салбар, санхүү, соёл урлаг, даатгал, боловсрол, болон хүнсний үйлдвэрлэл, эрүүл мэнд, эмийн салбарт хөрөнгө оруулалт хийж ТББ-уудийг дэмжин ажилладаг. Манай компанийн гадаад дотоод худалдааны бизнесийн гол гишүүд нь Япон, Орос, Хятад, Сингапур, Тайван, Тайланд зэрэг улсууд бөгөөд Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Тэргүүлэгч Гишүүн байгууллага юм.	
1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго	
Анх компани дээр тулгарсан асуудлуудаа шийдвэрлэх арга зам хайж Монгол-япон төвд суралцсан. Маш олон зүйлийг сурч удирдлагын арга барил чадвар олж авсан. Монгол-японы төвд сурч мэдсэн онолын ойлголтын мэдлэгээ бататгаж, практик дээр япон маягийн менежмент хэрхэн хэрэгждэг, яаж хэрэгжүүлдэг хэрэгжүүлэхэд тулгардаг зүйлс түүнийг хэрхэн даван туулж үр дүнд хүрсэн талаар мэдэж өөрийн компанид хэрэгжүүлж үйл ажиллагаагаа өргөжүүлэх, үр ашигтай болгох ирээдүйн	

бизнесийн салбараа тодорхойлох, хувь хүний хувьд юм үзэх соёлоос суралцах, харах онцөг, хандлагаа өөрчлөх, өөрийгөө нээх хөгжүүлэх зорилготой хамрагдсан.

2. Суралцсан зүйл

Энэ дадлага сургалтаар хувь хүний хувьд маш их зүйлийг сурч мэдсэн цаг хугацаа байсан. Сурсан харсан мэдсэн зүйлсээ хүлээн авч өөрийн дутагдал сул болон давуу талаа олж өөрчилж хэрэгжүүлж, хэвшүүлэх, өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх зорилготой өдөр бүр хичээн ажиллаж байна. Миний суралцсан зүйлс:

1. Япон хүний хүнлэг, найрсаг эелдэг аливаа зүйлд нягт нямбай, тууштай, аливааг хамгийн сайнаараа хийхийг эрхэмлэдэг чанар нь амжилтын үндэс гэж ойлгосон.
2. Хувийн зохион байгуулалт өөрийгөө хөгжүүлэх, бусдад хүндэтгэлтэй харьцах, багийн зохион байгуулалтаар ажиллаж хамтын шийдвэр гаргах чухал гэдгийг,
3. Хариуцлагатай байх. Хийж буй ажлын чанар, хугацаа, өгөөж үр дүнд онцгой анхаарч багийн гишүүдийн ажлыг хүндэтгэх нь чухлыг,
4. Цагийг хамгийн сайн, зөв төлөвлөж зарцуулах, ажиллах цагтаа ажиллаж амрах цагтаа амарч хэвших нь маш чухлыг суралцсан.

Мөн япон компаниудын амжилтын нууц менежментийн арга барилаас суралцлаа, Энэ аргыг сурч хэрэгжүүлж, хэвшүүлбэл маш олон зүйлийг хэмнэж, товчилж амжилттай бизнестэй болох бизнесээ амжилттай удирдах боломжтой юм байна.

- Бизнес хийхэд Компанийн философи маш чухал үүрэгтэй байхаас гадна байгууллагын үзэл баримтлал нь ажилтны зорилготой нэг байх нь маш чухал юм байна.
- **“Omotenashi” Үйлчлүүлэгчийн үйлчилгээ** /үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг өсгөх
- **“Kaizen/тасралтгүй сайжруулалт** /бизнесээ жижиг алхмуудаар тасралтгүй сайжруулах.
- **“5S” Ажлын зохион байгуулалт** /япончууд нийтээрээ хэрэгжүүлдэг үр дүнтэй арга/
- Япончууд хүн төвтэй менежмент хэрэгжүүлдэг энэ нь хүнээ тасралтгүй хөгжүүлэх, сургах, тогтвортой байлгах үндэс болдог, мөн эрхэм зорилго, зорилтынхоо төлөө нэг зүг харах нь маш чухал
- Япон менежментийн арга барил, соёл, үйлчилгээний стандартаас суралцсанаар ирээдүйн бизнес, хувь хүний хөгжилд маш том нөлөө үзүүлэх боломжтой байна. Жишээ нь:
 - Системтэй, төлөвлөгөөтэй ажиллаж, үр дүн, өгөөжийг нэмэгдүүлнэ.
 - Орлого, ашигт ажиллагааг өсгөнө.
 - Тогтвортой, урт хугацааны амжилтад хүрнэ.
 - Цагийн менежмент, сахилга бат, харилцааны ур чадвар сайжирна.
 - Шинэ сорилттой нүүр тулж, асуудал шийдвэрлэх чадвар нэмэгдэнэ.
 - Гадаад, дотоод зах зээлд өрсөлдөх чадвартай болно.
 - Олон улсын бизнес эрхлэхэд дөхөм болно.

- Аливаа асуудлын шууд шалтгааныг олохоос илүү өдөөгч шалтгааны арилгах арга хэмжээ авах нь дахин асуудал гарах нөхцөл арилж асуудал хурдан шийдэгдэнэ.

- Илүү зохион байгуулалттай, үр ашигтай бизнес эрхлэх боломжтой.

Япончууд шинэ санаачилга, инновацад хөрөнгө оруулж, урт хугацааны тогтвортой өсөлтийг зорилгоо болгодог/ энэ хандлагыг өөрийн амьдрал, бизнест хэрэгжүүлбэл томоохон амжилтад хүрэх суурь болох юм байна гэж харсан.

Бас нэг сурсан зүйл гэвэл цэвэр цэмцгэр эмх цэгцтэй байдал нь тухайн орчныг өөрчлөөд зогсохгүй хүний сэтгэлийг цэгцтэй болгож хандлагыг өөрчилдөг юм байна.

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

- Хамгийн эхэнд ажлын төлөвлөгөөнөөс эхэлж байна. Төлөвлөгөөгөө улирал, хагас жилээр гаргаж улирал бүр үр дүгнэх
- Компанийн философи, эрхэм зорилго зорилтын ажилтнууддаа таниулах, ойлгуулах уулзалт хийх, ажлын төлөвлөгөө зохион байгуулалтыг шинээр баталж танилцуулах
- Аж ахуйн албанд ажиллаж байгаа хүмүүсийн ажлын уялдааг сайжруулах ажил үүргийн хуваарийг тодорхой болгох
- 5S аргыг хэрэгжүүлэн хэвшүүлэх, шалгах дүгнэх үр дүнг тооцох журам гаргах
- Kaizen тасралтгүй сайжруулалт хийх жижиг гэлтгүй бүх зүйлд ач холбогдол өгч бага багаар тасралтгүй сайжруулалт хийх
- Ажилтан бүрийг хөгжүүлэх, ажилдаа хандах хандлагыг дээшдүүлэх илүү мэргэжлийн түвшинд ажиллахад нь анхаарч сургалт, уулзалт, сургалтуудад явуулах мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх гэх мэт ажлуудыг төлөвлөгөөнд оруулж хэрэгжүүлэх
- Аливаа шийдвэр гаргахдаа хамт олны санал шийдвэрийг илүү анхаарч ажилдаа хэрэгжүүлэх
- Аливаа асуудлын шууд шалтгааныг олохоос илүү өдөөгч шалтгааны арилгах арга хэмжээ авч асуудлыг нэг мөр шийдвэрлэж байх болсон
- Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг илүү дээгүүр үзэж үйлчлүүлэгчийн үйлчилгээ сэтгэл ханамжийг өсгөх хөгжүүлэлт идэвхжүүлэлт хийх
- Сар бүр нэг сэдвээр уриа, тод үш гарган ажил зохион байгуулах ажилчдаа идэвхжүүлнэ.
- Үйлчилгээний соёл байгууллагын соёлыг нэвтрүүлэх түүнийг дагасан хяналт урамшууллын системийг би болгоно
- Өдөр бүр дасгал хөдөлгөөн хийж цаг гарган идэвхтэй хамруулж оролцуулна.
- Бүтээгдэхүүний өрөлт, зай ашиглалт үйлчилгээний стандартыг хэрэгжүүлнэ.

- Ажилтнууддаа жил бүр эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулж тогтмол ээлжийн амралтаар биеэр амрааж байх
- Дэвшилтэд технологийн аргуудыг хэрэгжүүлж нийтийн ариун цэврийн өрөөнд бидэ суултуур байрлуулж эмх цэгц, цэвэр цэмцгэр орчныг би болгоно.

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

- Компанийн ирээдүйн төлөвлөгөөг маш сайн тодорхойлж төлөвлөх
- Ажилтан бүрийн ажил мэргэжлийн дагуу тохирсон сургалтад хамруулах, дэмжих
- Ажилтан нэг бүрийг өөрийгөө хөгжүүлэхэд анхаарч дэмжлэг үзүүлэх
- Ажлын уялдаа холбоог илүү нарийн болгох ажлыг хөнгөвчлөх арга механизмыг авч хэрэгжүүлэх
- Ажлын зохион байгуулалт, үр дүнг нэмэгдүүлэх
- Хувь хүний хувьд тасралтгүй сайжруулалт хийж, хөгжүүлэх, өрөө манлайлж үлгэрлэн өөрчлөлтийг бий болгох
- Ажлаа маш сайн төлөвлөж зохион байгуулж цаг хугацаагаа тодорхойлон төлөвлөж сурах
- Эерэг хандлагыг түгээж нөлөөллийг илүү нэмэгдүүлэх
- Хийхийг хүссэн зүйлээ эсэргүүцэлтэй тулгарсан ч өөрийн оролцоогоо дээшлүүлж тэмцэж хэрэгжүүлэх
- Ажилдаа хувь хүндээ дээрх менежментийн аргийг хэрэгжүүлж хүндрэл бэрхшээл гарсан ч хамгийн сайнаараа хийж үр дүн гарах итгэлээр хичээж, суралцаж хэрэгжүүлэх зорилготой байна.

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Хувь хүн болон компани дээр тулгамдаж буй асуудлаа нарийн тодорхойлж, японд очих компаниа сайн судалж тулгамдаж буй асуудалтай холбоотой түүнээс хэрхэн гарах яаж шийдвэрлэсэн, сайжруулж болох арга зам байгаа талаар асуулт бэлтгэх
- Очсон газар үзсэн зүйлсийнхээ зургийг авч өдөр өдрөөр нэр өгч хадгалж тэмдэглэл хийж явбал дараа ирээд сэргээж харах, ажилдаа хэрэглэх, тайлан тавихад хэрэгтэй болно.
- Аль улиралд очих гэж байгаагаас шалтгаалан дулаан хувцастай явах
- Бид маш их азтай хүмүүс ийм боломж хэн бүхэнд амархан олдохгүй хэдийн богино хугацаа ч маш өргөн мэдлэг баялаг туршлага хуримлуулна. Хувь хүний хувьд том сэргэлт хөгжүүлэлт болно.

Нэр: Б. Отгонцэцэг

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2024

Анги: Удирдлагын анги



Ажиллаж буй байгууллагын нэр	Найсбэйкери ХХК
Албан тушаал	Захирал
Байгуулагдсан он	2015
Үйл ажиллагааны чиглэл	Талх нарийн боов
Нийт ажилтны тоо	85
Компанийн товч танилцуулга	
Манай Найсбэйкери ХХК нь 89bakery гэсэн бренд үүсгэн үйл ажиллагаа 2015 оноос анх ажиллаж эхэлсэн. Талх нарийн боов төрлийн 30 орчим нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн сүлжээ дэлгүүр, супермаркет болон зах худалдааны төвүүдээр өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэдээ өдөр бүр шинээр нь хүргэдэг.	
1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго	
Япон дахь дадлага сургалтад сууснаар япон маягийн менежментээс суралцаж газар дээр нь нүдээр үзэж туршлага судлах, үйлдвэрлэлийн чанар аюулгүй байдал болон процесс хяналт шалгалт хэрхэн хийгддэгийг туршлага судлах хүсэлтэй байсан. Мөн япон соёл , япон чанарын үндсэн нь юунд байдгийг мэдэх хүсэлтэй байсан. Шинэ бүтээгдэхүүний санаа, сав баг баглаа боодол үйлчилгээ талаар туршлага судлах зорилготой байсан.	
2. Суралцсан зүйл	
Монгол япон төвийн япон дахь дадлага сургалтад сууснаар маш их зүйл суралцсан байна үүнд: Танилцсан үйлдвэр болон компани бүр өөрсдийн бизнесийн утга учир философийг тухайн байгууллагын ажилтан бүр ойлгон чин зүрхнээсээ хандан ажилладаг ажиглагдсан.	

- Олон жилийн түүх үе дамжсан бизнес соёл – бизнесийн байгууллагууд нь ихэнхдээ 100-аас дээш жилийн настай хэд хэдэн үе дамжин өвлөгдөн ирсэн бизнес байсан. Тогтвортой хөгжлийн бодлого боловсруулах, бизнесийн үйл ажиллагаагаа 20-30 жилээр биш 200 300 жилээр харах бодох хэрэгтэйг ойлгосон.
- Япон чанарын удирдлага нь аливаа гологдол болон асуудлын үндсэн шалтгааныг олж тогтоон дахин тухайн асуудал давтагдахгүй байхаар үндсээр нь шийдэж ирсэн нь чанар стандарттай нь шууд холбоотой байна.
- Япон менежментийн гол агуулга нь ажилтан бүрт сургалт чиглүүлэг ямар ч хүн уншихад ойлгомжтойгоор зураг болон бичгээр заавар зааварчилгааг өгч сурган дүрэм журмыг танилцуулах сургалтыг маш нарийн тодорхой хийдэг юм байна.
- Никкэй месей, Фүүдэкс үзэсгэлэн үзэж дэлхийн олон төрлийн хүнс үйлдвэрлэгч компаниудтай танилцаж түнш болох алхам хийх боломжтой, компанийн өнгө төрх ялгарлыг хэрхэн бий болгож байгааг нэг дор үзэж танилцсан. Хэрхэн сайн түнштэй амжилттай холбоо тогтоох талаар сургалтаар үзэж тухайн үзэсгэлэн дээр дадлагажуулсан нь үнэхээр үр дүнтэй байсан.
- 5с хэрэгжүүлэлтийг газар нь үзэж танилцан эмх цэгц хэрхэн бий болгож, ажиллах орчныг тав тух үүсгэх, үр ашиггүй зардлыг бууруулж, хамт олны уур амьсгалыг илүү дотно болгож байдгийг суралцсан.

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

- Бизнесийн гол ажиллагаа нь утга учиртай байх компанийн философи зорилго зорилтыг ажилтан бүр мэддэг, байгууллагын эерэг соёлыг тогтоон байнга сургалт болон ярилцлагыг тогтмол хийж хэвшүүлэх нь соёлын бий болгодог юм байна. Тиймээс байгууллагын соёлын сургалтыг байнга хийхээр төлөвлөж байна.
- Байгууллагын процесс зураглалаа дахин төлөвлөн хийж ажлын байр болгоны ажлын зураг авалтыг эхлүүлэн процессоо сайжруулах ажил хийж эхлээд байна.
- Ажлын байр тус бүр дээр заавар зааварчилгаа чек листийг нарийн сайн бэлтгэж зурган болон бичгийн зааварчилгаа ажлын байр болгоны хараа түвшинд бичиж тайлбараар тавих
- 5S нэвтрүүлж үйлдвэрийн бүтээмж нэмэгдүүлж эмх цэгцийг сайжруулах
- Чанар стандартын доголдол гарвал 5W алхмаар асуудлын үндсэн шалтгааныг олж тогтоон процесс сайжруулалт хийгдэх.

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

- Чиглүүлэх болон дадлагдажуулах сургалтыг тогтмол хийх (сургалт бол зардал биш хөрөнгө оруулалт юм байна)
- Байгууллагын алсын хараа, эрхэм зорилгыг ажилтан бүрд ойлгуулж байгууллагын эерэг соёлыг бүрдүүлэх
- Зардлын бууруулах болон бүтээмжийг нэмэгдүүлэх аян байнга хэрэгжүүлэх
- Өөрийгөө илүү сайн хөгжүүлэх
- 5с хэрэгжүүлэх
- Стандарт болон дүрэм журмыг маш сайн тодорхой гаргах

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Зураг сайн дарж авах

Тэмдэглэлийн дэвтэр дээр өдөр бүр маш нарийн тэмдэглэх

Нэрийн хуудас дэвтэр дээрээ хадах үдээсний машинтай байх

Цаг сайн барих

Нэр: **Баясгалан Санчир**

Үндсэн сургалтад хамрагдсан он: **2024**

Анги: **Менежерийн анги**



Ажиллаж буй байгууллагын нэр	Найсбэйкери ХХК
Албан тушаал	Ерөнхий менежер
Байгуулагдсан он	2015
Үйл ажиллагааны чиглэл	Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл
Нийт ажилтны тоо	85-90
Компанийн товч танилцуулга	
Манай “Найсбэйкери” ХХК нь 2015 онд байгуулагдаж хүнсний (гурил ,гурилан бүтээгдэхүүн) үйлдвэрлэлээр үйл ажиллагаа явуулж эхлээд одоогоор 80-90 хүний бүрэлдэхүүнтэйгээр 30 нэр төрлийн бүтээгдэхүүнийг бүх сүлжээ дэлгүүр болон зах бөөний төв, хүнсний дэлгүүрүүд мөн CU , GS-рүү хүргэн нийлүүлэн ажиллаж байна.	
1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго	
- Хүнсний үйлдвэр болон бусад үйлдвэрийн дотоод үйл ажиллагаатай танилцах, үйлдвэрийн дотоод зохион байгуулалт хөдөлгөөний урсгал, ХАБ, чанар стандартыг хэрхэн хэрэгжүүлж байгаагаас суралцах. - Шинэ бүтээгдэхүүний судалгаа, сав баглаа боодол, шошгын мэдээллийг судлах. - Япон менежмент - Япон чанар - Япон соёл - Бизнесийн шинэ хамтрагчтай хэрхэн амжилттай яриа хийх - Тоног төхөөрөмжийн судалгаа - Хувь хүний хөгжил	
2. Суралцсан зүйл	
- Дадлага сургалт буюу анхлан суралцагчдад мөн шинэ хүрээлэлд орж байгаа хүмүүст хамгийн хэрэгтэй урт хугацаандаа их өр өгөөжтэй байсан. - ХАБ-г хангасан ажлын байрыг жижиг дитал болгон дээр шийдсэн, зааварчилгаа анхааруулгыг алхам тутам байршуулсан байсан.	

3. SDG –ийн ач холбогдол, бүрэн автоматажсан үйлдвэрийн бүтээн байгуулалт нь үйлдвэрийн гарц бүтээгдэхүүний чанар стандартыг нэмэгдүүлэх маш их ач холбогдолтойг
4. Хүний нөөцийг анхаарч идэвхжүүлснээрээ бүх хүний оролцоог сайжруулж ажлын байран дээрээ шинэчлэлт хийж ажлыг жаргаж хийж, санаачилгатай бага хамт олон болж болдгийг
5. Бэлтгэл ажил маш сайн хангагдсан байвал дараа дараагийн алхмууд амжилттайг болдгийг.
6. Санхүүгийн эх үүсвэртэй, эрсдэлийг даван гарах санхүүгийн хадгаламжтай байснаараа компани урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах, шинэ салбар бизнестэй болох боломжтойг
7. Зорилтот хэрэглэгчдэдээ тодорхойлж чадсанаараа үнэ дагасан чанарыг үйлдвэрлэж,
Үнэ болон бараа бүтээгдэхүүнээрээ маркетинг хийж хэрэглэгчдэдээ нэмэгдүүлж болдгийг.

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

1. Шинэ ажилчдадаа дадлага сургалтад хамруулах
2. ХАБ хангасан зааварчилгаа, анхааруулгыг дахин нэмж байршуулах
3. 5S ийн хүрээнд бүх ажилчидаа оролцуулж урамшуулах
4. 5W хүрээнд алдаа гаргасан хүнийг бус уг үндсийг олох
5. Зардлаа хянах илүү зардлаа багасгах тал дээр анхаарах
6. Үйлдвэрлэлийн процессыг сайжруулах тогтмол бүртгэл хөтлөх
7. Тогтвортой хүний нөөцийг бэлдэхийн тулд АБТ-г ойлгомжтой болгох
8. Яагаад япон менежмент мундаг вэ асуумж асууж бага багаар ажлын байран дээрээ нэвтрүүлэх
9. Зорилтод хэрэглэгчдэдээ тодорхойлж шинэ бүтээгдэхүүний санал оруулах
10. Үйлдвэрийн ажилчдын сэтгэл зүй, аз жаргалтай хамт олон байхын тулд тогтмол сургалт, олон нийтийн үйл ажиллагаа явуулах

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

1. Компанийн үнэт зүйлийг бий болгох
2. Хувь хүний хувьд эерэг бас байнга өөдрөг байх тал дээр суралцах
3. Багахан зүйлийг ч сэтгэл гаргаж хийх
4. Олон талаас харах, дүн шинжилгээ хийх, асуудлыг шийдэх боломжийг хайх
5. Итгэл үнэмшил зорилгодоо үнэнч байх
6. Авах биш өгөх сэтгэлгээгээ нэмэх
7. Суралцах хөгжих тал дээр идэвхтэй байх
8. Хүн байх, ёс зүйтэй байх
9. Оролцоотой байх
10. Ярилцах ойлголцох асуудлыг нэгт тавих

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

1. Дадлага сургалтаар заасан зүйлсийг дор бүр нь биелүүлэх бэлтгэх
2. Зорилгоо тодорхой болгох
3. Сониуч гярхай байх
4. Бэлтгэл ажил бүрэн хангагдсан байх
5. Эрүүл мэндээ анхаарах
6. Сургалтын мэдээллээс хоцрохгүй байх
7. Дүрэм журмаа сайн дагах

Нэр: Б.Сарнай

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2024

Анги: Удирдлагын анги



Ажиллаж буй байгууллагын нэр	Jade rose ХХК
Албан тушаал	CEO
Байгуулагдсан он	2018
Үйл ажиллагааны чиглэл	Үйлчилгээ
Нийт ажилтны тоо	30
Компанийн товч танилцуулга	
JADE ROSE LLC / Жейд Рөүз ххк 2018 онд 60 хүний багтаамжтай ресторан лаунж чиглэлээр үйл ажиллагаа анх эхэлж байсан. Улаанбаатар хотын төв цэгт монгол болон европ хоолоор үйлчилж ажилчдын өдрийн хоолыг өөрийн хэрэгцээ, санхүү, эрүүл мэндэд тохирсон олон сонголтоос сонгох боломжийг бүрдүүлж өгснөөрөө олон хүний таашаалд нийцсэн ресторан бий болон ажиллаж байна. Одоогоор 105 хүний суудалтай болон өргөжсөн байна. Jade Treasure LLC / Жейд Треажур ххк салбар компани болох 2020 оноос гадаад худалдааг эрхэлж байна. Солонгос улсын Cellpluss компани Sweet page брендыг албан ёсны эрхтэйгээр борлуулж байна. Уг бүтээгдэхүүн маань кофе шоп, рестораны шаке, смүүти, латте, хүйтэн, халуун уух зүйлийн бэлдэц байгаа.	
1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго	
Япон компани соёл, бизнесийн цар хүрээ, бүтээгдэхүүн үйлчилгээ, болон бизнесийн дараагийн бүтээгдэхүүн үйлчилгээг судлах зорилготой байсан.	
2. Суралцсан зүйл	
Өөрийн бизнесийг хэрхэн төрөлжүүлэх, бизнес хөгжүүлэлт, бараа бүтээгдэхүүний чиг хандлага компани нийгэмд ямар үнэ цэнэ бүтээснээрээ өөрийн амжилтыг бүтээж болдгийг сурсан Компани хэний ямар асуудлыг шийдэх гээд байгаа. Манай байгууллагаас бүрэн үйлчилгээ авч чадаж байгаа эсэх	

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

Байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлийг ахын шинээр хийх. Бүх ажилчдаа байгууллагын хаашаа явж юунд хүрэх гэж байгааг ойлгуулах Мөн ажилчдаа хүсэл зорилгоор нь удирдах

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

Цаашид япон компани болон хүнийг судалж бизнесийн хамтралыг хайх. Өөрийн байгууллагаар дамжуулан улс их орон доо хувь нэмэр оруулах Мөн үйлчилгээний салбарт шинэ өнгө, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхийг зорьж байна. Хувь хүний хувьд хэтийн зорилго үйлдвэрлэгч, болон бүтээн байгуулагч болох асар их хүсэлтэй болсон.

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Очсон газартаа үр дүнтэй 100% байж. Яагаад энэ гэж. Юунд зориулж юунд хэрэгтэй юм бол гэсэн хандлагаар харж нээлтэй байж. Асууж мэдмээр байгаа зүйлээ санаа зоволгүй асууж байх. Яагаад манай байгууллага ийм болж болохгүй гэсэн өнцгөөр харж яваарай. Гоё сайхан зүйлийг хараад бишрэхийн хэрээр өөрийн байгууллага улс их орондоо яах уу гэсэн бодолтой байгаараа. Аливаад сониуч байж. Япон компани философийг нь судалж ажиглаарай

Нэр: О.Уянсайн

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2024

Анги: Удирдлагын анги



Ажиллаж буй байгууллагын нэр	Гэрэгэ Системс ХХК
Албан тушаал	Стратеги хариуцсан захирал
Байгуулагдсан он	2017
Үйл ажиллагааны чиглэл	Мэдээллийн технологи
Нийт ажилтны тоо	120
Компанийн товч танилцуулга	
“Гэрэгэ Системс” нь анх 2017 онд байгуулагдаж одоог хүртэл Төрийн болон хувийн хэвшлийн үйлчилгээг хялбар аргаар иргэдэд хүргэх зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулсаар байна. 2022 онд бид групп компанийн засаглал нэвтрүүлж “Гэрэгэ Киоск” ХХК, “Гэрэгэ ПОС” ХХК, “Гэрэгэ Проперти Техноложис” ХХК, “Гэрэгэ Медтек” ХХК, “Гэрэгэ Эдтек” ХХК, “Гэрэгэ Пэй” ХХК зэрэг охин компаниудтай болж цар хүрээгээ өргөтгөсөн. Одоогоор 120+ ажилтан “Гэрэгэ Системс”-ийг бүрдүүлж байна. “Гэрэгэ Платформ”-ийн киоск машинаар сард 250 мянган хүн үйлчлүүлж төрийн болон хувийн хэвшлийн үйлчилгээг иргэд түргэн шуурхай авч байна. Киоск машины нийт үйлчилгээний 70 хувь нь төрийн албаны үйлчилгээ эзэлдэг. Мөн кассын машиныг орлох “Гэрэгэ Пос”-оор шууд төлбөрийн үйлчилгээ болон дээрх үйлчилгээнүүдийг давхар авах боломжтой. Мөн эрүүл мэндийн асуудал тулгарсан үед та “Гэрэгэ Медтек” компаниар дамжуулан үйлчилгээ авах боломжтой.	
1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго	
Миний Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго нь: - Японы компаниудын стратеги, соёлыг ойлгох - Манай компанийн үйл ажиллагааг сайжруулах арга замыг тодорхойлох - Бусад Монгол оролцогчидтой харилцаа холбоо тогтоож, мэдлэг хуваалцах Мөн манай компанийн Food Kiosk программыг бүтээж байгаа тул түүнийг цаашид сайжруулах, экспортлох боломжийг судлах зорилготой байсан.	

2. Суралцсан зүйл

- Олон улсын экспод оролцох болон бүтээгдэхүүнээ танилцуулах, хамтрагч олоход бодит байдал дээрээс туршлага судалсан.
- Жижиглэнгийн дэлгүүрүүдийн зорилтот зах зээлийн ялгаа, түүнийгээ стратеги, бүтээгдэхүүн, байршил, дэлгүүртээ хэрхэн холбож байгааг сурсан.
- Компания удирдахад доорх зарчмуудыг баримталбал урт хугацаандаа үр дүнтэйг ойлгосон:
 - Энгийн зарчим, үнэт зүйлийг эрхэмлэж, урт хугацаанд бизнесээ тогтвортой хөгжүүлэх, өв залгамжлалд бэлтгэх.
 - Ажлын жижиг хэсэг бүрийг орхигдуулалгүй, тасралтгүй сайжруулснаар үр ашгийг нэмэгдүүлж, хөгжлийг хурдасгах.
 - Удирдлагын бодол, хандлага нь компанийн уур амьсгалд хүчтэй нөлөөлдөг тул, байгууллагын уналтын үед ч удирдлага эерэг, эрч хүчтэй байж, ажилчдаа манлайлах нь чухал.
 - Хөдөлмөр хөнгөвчлөх, зардлыг бууруулах санаачилгыг ажилчдаас гаргуулж, урамшуулах замаар бүтээлч орчныг бүрдүүлэх.
 - Хүнс үйлдвэрлэж буй хүн инээмсэглэж, сайн сайхныг бодож хийх нь амт, чанарт нь хүртэл эерэг нөлөөтэй.

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

1. 5s хэрэгжүүлэх, Кайзены хороо байгуулах, систем тогтоох, Empowerment
2. Ресторан, кассын систем, төлбөрийн системээ экспортод гаргах, Customised программ хангамжийн хөгжүүлэлт санал болгох
3. Сэтгэл хөдлөл халдварладаг учир удирдлагын хувьд эерэг, эрч хүчийг ажилчдадаа халдварлуулах - SMILE

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

Олон улсын үзэсгэлэн яармагт Food kiosk, Gerege POS систем, программ хангамжаа танилцуулах, хамтрагч олох, экспорт хийх

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- FoodEx дээр уулзахыг хүссэн байгууллагаа урьдчилан маш сайн судлах, чадвал урьдчилан цахимаар холбоо тогтоогоод уулзах хүнээ, цагаа тохирсон байх
- Чадвал япон хэлний орчуулагчтай үзэсгэлэн дээр явах
- Урьдчилан тааварлаагүй хамтрагчтай таарвал уулзах завтай байх
- Японд байхад өглөөнөөс орой хүртэл ачаалал ихтэй байх тул очихын өмнө амралт сайтай явах.

Нэр: А.Чимэдцэрэн

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2023

Анги: Удирдлагын анги



Ажиллаж буй байгууллагын нэр	Мон эрц майнинг ХХК – Жоконди ХХК
Албан тушаал	Төсөл хариуцсан менежер, Маркетинг менежер
Байгуулагдсан он	2020 он – 2008 он
Үйл ажиллагааны чиглэл	Барилгын компани- Хүнс болон хувцасны брэнд дэлгүүрүүд
Нийт ажилтны тоо	25+

Компанийн товч танилцуулга

1. Мон эрц майнинг ХХК: Төсөл хариуцсан менежер

Манай компани нь 2020 онд байгуулагдсан Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 1-р хороо, нэгж талбарын 1460700329 дугаар бүхий 1400 м,кв талбай бүхий үйлчилгээтэй, орон сууцны зориулалт 16 давхар орон сууцыг ХУД-н 4-р хороонд баригдаж ашиглалтад орж байгаа Гэмтэл Сого, Мэс заслын төрөлжсөн 120 ортой эмнэлгийн ХБНГУ, АНУ, Япон, БНСУ, БНХАУ, ОХУ-аас ирэх гадаад эмч нарт зориулан олон улсад ажиллах эмч нарын гэр бүлийн хамт амьдрахад тусалцаа үзүүлэх мөн үйлчилгээгээр хангахад чиглэсэн юм.

Монгол улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг эх орондоо бүрэн авахын тулд өндөр хөгжилтэй орнуудын Их сургуулиудын эмч нарын багийг урт богино хугацаагаар авчирч ажиллуулан дотоодын эмч нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх, хамтран мэс заслын эмчилгээг эх орондоо хийх ажлыг 2018 оноос дотоодын компаниудын түншлэл хэрэгжүүлж эхлээд байгаа болно.

2. Жоконди ХХК: Импорт болон маркетинг менежер

Манай компани нь 2008 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа “Хариуцлагатай Хувьцаат Компани” юм.

- СМЕРАЛДА хүнсний дэлгүүртээ монгол дахь импортлогч компаниудтай хамтран ажиллахаас гадна итали улсаас Redoro”, ”Bortolotti” -зэрэг брэнд бүтээгдэхүүнийг албан ёсны эрхтэй импортолдог бөгөөд бусад сүлжээ супермаркет болон ресторануудад нийлүүлэлт хийдэг.
- BALDININI” брэндийг анх 2017 онд Монголын зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд 7 жилийн хугацаанд бид байнгын үйлчлүүлэгчтэй болж Улаанбаатар хотын А

бүсэд байрлах олон улсын сүлжээ “Shangri-La Mall” худалдааны төвд үйл ажиллагаагаа явуулж байна.

1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

1. Япон дахь дадлага сургалтаас өөрийгөө хөгжүүлэх, сурч мэдсэн зүйлээ хамт олондоо хуваалцах, ажил, бизнестээ үр ашигтайгаар хэрэгжүүлэх, бизнесээ хөгжүүлэх зорилготой
2. Бизнесээ өргөжүүлэх:
Дэлхийн томоохон үзэсгэлэн худалдаанаас FOODEX JAPAN-25 / ХҮНСНИЙ ДЭЛГҮҮР-тээ хүнсний бүтээгдэхүүнүүд/ NIKKE MESSE Франчайз үзэсгэлэн худалдаанаас /ГОО САЙХНЫ брэнд/ судлах бизнесийн хамтрагчаа олох , бизнесээ өргөжүүлэх зорилготой.

2. Суралцсан зүйл

ЯМТөвийн үндсэн сургалт 23 дахь төгсөлт CEO сургалтаас сурч мэдсэн зүйлээ Япон оронд өөрийн нүдээр бодитоор харж, сонсож, олон зүйлийг сурч бататгаж ирлээ. Энэ сайхан сургалтад суух боломжийг олгосон ЯМТ болон JICA төвийн хамт олонд гүнээ талархаж байна.

Бататган сурч мэдсэн зүйлс:

Японы компаниудаас: япон маягийн менежмент, комплаенс, удирдагчийн манлайлал /SDG/ тогтвортой хөгжлийн зорилтуудыг компаниуд хэрэгжүүлдэг ингэснээр инновацыг нэвтрүүлэх, компанийнхаа үнэ цэнийг нэмэгдүүлэх, ESG – компани урт хугацаанд хөгжих боломжуудыг харсан

- Томоохон худалдааны төвүүдээс: маркетингийн менежмент /мерчендайз/
- FOODEX JAPAN-2025, NIKKE MESSE-с бизнесээ өргөжүүлэх харилцагчдадаа олсон мэйлээр харилцаж байгаа /хүнс болон бусад/
- Чанар удирдлагын менежмент:

Олон улсын стандарт ISO9001 + Япон маягийн чанарын удирдлага TQC бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх, гологдол бүтээгдэхүүнийг багасгах, үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх TQM: удирдлагын бүх л хүрээнд хэрэгжүүлэх, Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлж нийт үйлдвэрлэлийн хүрээнд чанарыг сайжруулах, урт хугацааны амжилтыг гаргах, 5W шиншилгээ хийж өдөөгч шалтгааныг олох зэрэг...

5S – Ажлын байрыг цэвэрхэн болгох

5S –Ажиллах хүчний ухамсрыг өөрчлөх **зэргийн ажил бизнестээ үр ашигтайгаар ашиглах, хэрэгжүүлээд улам гүнзгийрүүлэн суралцаад явна.**

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

- ACTION PLAN					
ЖОКОНДИ ХХК-НИЙ BALDINI БРЭНД БОЛОН СМЕРАЛДО СУПЕРМАРКЕТ-Д ХЭРЭГЖИХ ACTION PLAN 01/04/2025					
Хийгдэх ажил	Хариуцагч	Эхлэх	Дуусах	Тэмдэглэл	Гарах үр дүн
Компаний стратеги - HR					
Япон дахь дадлага сургалтаас олж авсан мэдлэгээ ЖОКОНДИ ХХК-ний хамт олонд сургалт орно / Менежрүүд болон худалдааны зөвлөхүүдэд/ 3 удаа	А.Чимэдцэрэн	7/4/2025	30/4/2025	Япон дахь сургалтаас	Компаниас явуулж байгаа үйл ажиллагааг илүү сайн ойлгох ажилчид болон хэрэглэгчдын харилцаа холбоо сайжрах, компанид итгэх итгэл нэмэгдэх, хүний нөөцийн орол, гаралт багасах, борлуулалт өснө.
STP: Компаний үйл ажиллагааг сайжруулах тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх /SWOT/	Гүйцэтгэх захирал Д.Эрдэнэтуул А.Чимэдцэрэн	1/5/2025	31/12/2025	B2B, B2C, C2C болон борлуулалт, ахуйц ашиг, тогтмол зардлын талаар арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.	
Экспортын бүтээгдэхүүн нийлүүлэх боломж бий болгож бизнесээ өргөжүүлнэ /хүнс болон гоо сайхны брэнд/ SDG	А.Чимэдцэрэн Т.Туяа	15/03/2025	31/12/2025	FOODEX JAPAN -2025 үзэсгэлэн худалдаан; хүнсний компаниуд / солонгос, япон, франц/ гоо сайхны брэндтэй холбоо харилцаага үр дүнтэй болгож ажил болгоно.	Нийлүүлэгчийн зааврын дагуу мөн өөрсдийн онцлогт тохируулах зах зээлд нэвтрүүлэх ингэснээр брэнд илүү танигдана, шинэ бүтээгдэхүүн өөрөө сурталчилгаа болно. борлуулалт нэмэгднэ
МОНГОЛ ЯПОНЫ ТӨБ-тэй харилцаа хобоотой ажиллах, сургалт авах	А.Чимэдцэрэн	2025 оон 2026		Компани хөгжүүлэх, бизнесээ өргөжүүлэхэд үр дүн өндөртэй байх сургалтууд /япон багш нараас авах / SDG , ESG	
Худалдаа Маркетинг стратеги -BALDINI БОЛОН ШИНЭ БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮНҮҮДэд					
Салбар дэлгүүрүүдэд мэдээлэл цуглуулах аргачлалаа сайжруулж, Loyalty Program нь CRM -н гол хэрэгсэл үүнд анализ хийх /baldini болон Барилга дээр/	Т.Туяа А.Чимэдцэрэн	10/4/2025	31/12/2025	Маркетинг сошиал сувагууд болон бусад үйл ажиллагааг сайжруулна сонирхолтой байдлаар хөтлөх, харуу өгнө	Компани болон брэндийн нэр хүндэд эерэг нөлөөтэй хэрэглэгчдийн сэтгэл ханаж нэмэгдэх, дахин худалдан авалт хийх борлуулалтаа мөн DATA баазаа нэмэгдүүлнэ.
Борлуулалт болон маркетингийн хийсэн ажил бүрдээ хэмжилт хийнэ (KPI) сар бүр					
STP: Хэрэглэгчийн сегмент бүрт зориулан өөр өөр маркетингийн аргачлал ашиглах /урамшуулал, масс	А.Чимэдцэрэн Т.Туяа	2025 оон 2026		Маркетингийн идэвхжүүлэлт явуулах, борлуулалт нэмэгдэх болон хэрэглэгчдийн сэтгэл ханаж дээшлэх, мөн зөв хэрэглэгчид зөв мэдээлэл хүргэх зорилготой.	
STP: Үргэлж борлуулалтаа хянаж хэмжилт хийнэ зардалаа хянах - Маркетингийн хийгдсэн ажил бүрийн дараа хэмжиж KPI хөтлөлтөө илүү сайжруулна				KPI -н боловсронгуй загвар гаргах, хянах ямар маркетингийн ажил илүү үр дүнтэй байгаагаа харах , зардалаа хянах	

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

Компанийн хувьд:

- Япон маягийн менежментийг компанидаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ бүх түвшиндээ хэрэгжүүлнэ,
- Импортын бүтээгдэхүүн судлах зах зээлд нэвтрүүлэх, бизнесээ өргөжүүлнэ

Хувь хүнийхээ хувьд

- Сурч мэдсэн зүйлээ ажил, амьдралдаа үр бүтээмжтэй хэрэгжүүлнэ.

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Монгол Япон төвийн сургалт болон Япон дахь дадлага сургалтад та хамрагдах боломжийг авсан бол сургалт бүрт ач холбогдол өгч үр бүтээмжтэй сурч тус мэдлэгээ илүү олон хүнд түгээгээрэй!

ТАЛАРХАЛ:

МОНГОЛ ЯПОНЫ ТӨВ болон ЛСА ХАМТ ОЛОН, БҮХ СУРГАГЧ БАГШ НАР , ХАМТРАН АЖИЛЛАДАГ АЖИЛЧДАД НЬ ГҮНЭЭ ТАЛАРХАЖ БАЙГААГАА ИЛЭРХИЙЛЖ БАЙНА.

Нэр: Намсрай Энхжаргал

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2021

Анги: Удирдлагын анги



Ажиллаж буй байгууллагын нэр	Өгөөмж Архад ХХК
Албан тушаал	Гүйцэтгэх Захирал
Байгуулагдсан он	2000
Үйл ажиллагааны чиглэл	Нарийн боов үйлдвэрлэл худалдаа
Нийт ажилтны тоо	160
Компанийн товч танилцуулга	
Өгөөмж Архад ХХК нь 2000 онд үүсгэн байгуулагдсан. Нарийн боов худалдаа үйлдвэрлэлийн чиглэлээр 25 жил 160 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Нийт 20 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг ба хэрэглэгчдэдээ амт чанараараа Монголчууддаа танигдсан. 2024 онд MNS ISO 9001: 2016 Чанарын менежментийн тогтолцооны стандартын баталгаажилтаа авсан. Манай чанарын менежментийн тогтолцооны бодлого нь “Бид Монгол хүний ур ухаанаар сэтгэлд хүрсэн амтыг бүтээн хэрэглэгчдэдээ хүргэж менежментийн тогтолцоог тасралтгүй сайжруулан, хүн байгаль, нийгэмдээ ээлтэй үйлдвэрлэгч байна.” Мөн MNS ISO 14001:2016 Байгаль орчны менежментийн тогтолцооны стандарт болон ISO/IEC:17025 лабораторийн итгэмжлэл зэргийг нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.	
1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго	
Японы урт настай компанийн менежментийн тогтолцооноос суралцах Япон компаниуд өв залгамжлалыг яаж шийддэг талаар суралцах Нарийн боовны орчин үеийн чиг хандлага түүний сав баглаа боодлоос санаа авах Нарийн боовны техник тоног төхөөрөмж технологийн хөгжлийг судалж суралцах зорилготой явсан.	

2. Суралцсан зүйл

Энэ сургалт нь шинэ мэдлэг өгөөд зогсохгүй өөрийн бизнесээ шинэ өнцгөөс харах боломж нээгдсэн. Японы нарийн зохион байгуулалт өндөр стандарт, урт хугацааны бодлого хэрэгжүүлдэг арга барил нь маш том урмыг өгсөн. Эндээс менежментийн тогтвортой хөгжил, багийн хамтын ажиллагаа, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх олон чухал арга барил сурсан.

Чанарын тогтвортой байдал, үйл явцын тасралтгүй сайжруулалт, ажилчдын ур чадварыг хөгжүүлэх зарчмуудыг хүнсний үйлдвэрлэлд шууд хэрэглэж болох боломжтой гэдгийг ойлгосон.

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

Энэ бүхнийг эхлэхийн тулд хамгийн түрүүнд хамтран ажиллагсад болон ажилчдадаа Японы менежментийн арга барил болон чанарыг эрхэмлэдэг соёлтой хүмүүс гэдгийг харсан.

Япон ард түмэн нь эх оронч сэтгэлгээтэй, ажил амьдралдаа чин үнэн зүрх сэтгэлээ шингээн ажиллаж чанартай бүтээл гаргадаг. Эдгээр сайхан шинж чанаруудыг бүх хамтран ажиллагсад баг хамт олондоо менежментийн багийн сургалтаас эхэлж цаашдаа хэрэгжүүлж бодит үр дүн гаргана.

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

Манай компани зөвхөн бизнесийн амжилтаас гадна нийгэм байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэхийг зорьдог. Иймд бид Тогтвортой хөгжлийн зорилгуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж илүү тогтвортой хариуцлагатай бизнес хийхийг зорьж ажиллаж байна.

Хувь хүний хувьд цагийн менежменттэй, нарийн төлөвлөлт нарийн дадлуудыг хэвшүүлсэн байна. Мөн ажлын хариуцлагатай, сахилга баттай, асуудалд илүү стратеги дэс дараатай хандаж аливаа зүйлийг тасралтгүй сайжруулах хандлага төлөвшүүлнэ. Энэ нь хувь хүнд болон бизнест урт хугацааны зорилгоо тодорхой болгоход илүү тустай.

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Сургалтаас юу хүсэж байгаагаа тодорхой болгох хэрэгтэй.

Тодорхой зорилготой очсоноор тухайн хувь хүн эргэлзэхгүй, компаниуд болон үзэсгэлэнгээс арай илүү оновчтой мэдээллийг олж авч чадна гэж харсан.

- Асуулт асууж хэлэлцүүлэгт оролцож өөрийн санаа бодлоо хуваалцаарай
- Урьдчилан өгсөн сургалтын материал гарын авлагыг анхааралтай уншиж ойлгоорой
- Сургалтынхаа хуваарийг мөрдөж цагаа баримталж, үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлэх
- Шинэ мэдлэг ур чадвар эзэмшихэд нээлттэй, эерэг хандлагатай байх байнга тэмдэглэж авах
- Суралцсан зүйлээ ажил амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан үр дүн гаргах
- Сургалт зохион байгуулагчдад санал хүсэлтээ чөлөөтэй илэрхийлэх

Нэр: М. Энхмандах

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2024

Анги: Удирдлагын анги



Ажиллаж буй байгууллагын нэр	Инно Хими Лаб ХХК
Албан тушаал	Гүйцэтгэх захирал
Байгуулагдсан он	2023
Үйл ажиллагааны чиглэл	Хүнс, хүрээлэн буй орчны шинжилгээний лаборатори Химийн тоног төхөөрөмж, урвалж, багаж хэрэгслийн худалдаа
Нийт ажилтны тоо	10

Компанийн товч танилцуулга

“Инно хими лаб” ХХК нь

- Худалдаа: Аналитик лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, химийн бодис, нэг удаагийн хэрэгслийг нийлүүлэх, суурилуулах, турших, засвар, тохируулгын ажлыг гүйцэтгэх,
- Химийн лабораторийн шинжилгээ, судалгаа хийх, сургалт зохион байгуулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр байгуулагдсан.

Инно Хими Лаб ХХК – ийн Инно лабораторийн шинжилгээ нь дараах төрөлтэй:

- Хүнс, хүрээлэн буй орчны аюулгүйн үзүүлэлтийн шинжилгээ: Пестицидийн үлдэгдэл, афлатоксин, органик бохирдуулагчид
- Хүнсний чанарын шинжилгээ: Хүнсний витамин, амин хүчил, тосны хүчил болон кофеин

Бид Монгол улсад химийн бүтээгдэхүүний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл болон лабораторийн ур чадварын MNS ISO/IEC 17025:2018 олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

- Хүнсний чанар, аюулгүй байдлыг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байдлыг судлах
- Хүнсийг экспортод гаргахад лабораторийн үүрэг оролцоо олон улсад ямар хэмжээнд байгааг судлах
- Япон чанарын нууцаас өөрийн компанид хэрэгжүүлж болох мэдлэг олж авах

2. Суралцсан зүйл

Суралцсан зүйлсээ бүрэн илэрхийлж чадахааргүй их зүйлийг харж, мэдэрч суралцлаа. Сургалтын агуулга, зохион байгуулалт, бэлтгэл болон орчуулга гээд бүх зүйл төгс буюу өөрөө суралцахуйц процесс байлаа. Маш их баярлалаа.

Менежментийн мэдлэг:

1. Үйл ажиллагааны процессыг тодорхой болгох
2. Үйл ажиллагаа тус бүрийг хариуцах эзэнтэй болгох
3. Үйл ажиллагаа бүр заавартай, гарын авлагатай ойлгомжтой байх
4. Асуудлаа юу гэж үзэх, түүнийг хэрхэн засаж, тасралтгүй сайжрах аргыг хэрэгжүүлэх
5. Менежментийн олон аргуудаас өөрийн үйл ажиллагаанд тааруулан сонгон авч хэрэглэх чухал ч түүний ач холбогдлыг компанийн ажилтан бүр ойлгож, тууштай байх ёстойг суралцлаа.

Хүний нөөцийн мэдлэг:

6. Багийн гишүүн бүр өөрийн гэсэн ур чадвартай, түүнийг нь илрүүлэх нь удирдлага хүний үүрэг ямар байх
7. Орон нутагтаа хариуцлагатай байдал нь эргээд хүний нөөцийн асуудлын шийдэл болох
8. Хүний нөөц бол тасралтгүй сургалттай байх

Хүнсний салбарын мэдлэг:

9. Япон хүнсний чанарын үндэс болох арга ажиллагаа болон стандартын тухай
10. Япон компаниудын хөгжилд технологийн дэвшлийн оролцоо
11. Олон улсын зах зээлд өрсөлдөхөд хэрэгжүүлэх шаардлагатай стандартуудын тухай

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

Зохион байгуулалт

1. Компанийн үйл ажиллагаануудыг загварчлах
2. Үйл ажиллагаа тус бүрийг хариуцсан эзэнтэй болгох
3. Үйл ажиллагааг заавартай ойлгомжтой болгох
4. Хитачигийн чанарын удирдлага, 5S зэрэг аргуудыг компанидаа хэрэгжүүлэх

Сургалт

- Монгол Япон төвийн сургалтад ажилтнуудаа хамруулах
- Компанийн дотоодод сургалтын багууд гаргах

Хүнсний салбар

1. Хүнсний салбарын бодлого боловсруулагчид, үйлдвэрлэл эрхлэгчдэд Жайка, Монгол Японы төвийн сургалтын талаар тайлбарлаж өгөх, сурталчлах
2. Дадлага сургалтад хамрагдсан багийн бусад гишүүдтэй хамтран хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг олон улсын жишигт хүргэхэд хувь нэмрээ оруулах

Хамтын ажиллагаа

- Foodex – ын үеэр уулзалт хийсэн Японы Atago лабораторийн тоног төхөөрөмжийн хамтын ажиллагааг эхлүүлэх, гэрээ байгуулах

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)
Компани:

- Лабораторийн ур чадварын ISO/IEC 17025:2017 стандартын итгэмжлэлийг олон улсаас авах
- Лабораторио цогц болгож, олон улсын шинжилгээний стандартуудыг нутагшуулагч болгон хөгжүүлэх
- Хүнсний аюулгүй байдал, чанарын чиглэлд олон нийтэд чиглэсэн мэдлэгжүүлэх төсөл хэрэгжүүлэх
- Бизнесээ улс орондоо өгөөжтэй, ёс суртахуунтай хийх, инновацыг тасралтгүй нэвтрүүлэх

Хувь хүн:

- Үргэлж инээмсэглэдэг хүн больё
- Байгаль дэлхийдээ ээлтэй хүн, гэр бүлийг, хүнийг бүтээе
- Эрүүл мэнддээ анхааръя

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Бид хүссэн үедээ Японд аялж болох ч, бизнес эрхлэгчдээс амжилтын нууц, философи, үйл ажиллагаагаа хэрхэн хийдэг талаар нь эх хэл дээрээ, цогц байдлаар ингэж сурах, харах боломж маш ховор олдох аз санагдлаа.

Азыг атгаж аваад, амьдралдаа хэрэгжүүлэх, улс орондоо хувь нэмрээ оруулах нь биднээс өөрөөс хамаарах зүйл тул эргэж ирээд хичээгээрэй.

Нэр: Ц.Энхтуул

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2024

Анги: Удирдлагын анги



Ажиллаж буй байгууллагын нэр	Супервижн Медиа Групп ХХК
Албан тушаал	Гүйцэтгэх захирал
Байгуулагдсан он	2006
Үйл ажиллагааны чиглэл	Хэвлэл мэдээлэл
Нийт ажилтны тоо	54
Компанийн товч танилцуулга	
SBN телевиз нь салбартаа олон бүтээмжийг анхлан нэвтрүүлж, хөгжлийг түүчээлсэн 19 жилийн түүхэн туршлагатай өргөн сувгаар мэдээлэл, контентыг шууд болон бэлтгэн цацдаг хэвлэл мэдээллийн мэргэжлийн байгууллага. Үйл ажиллагааны чиглэл нь: - БҮХ ТӨРЛИЙН КОНТЕНТ - БҮХ ТӨРЛИЙН КИНО, БАРИМТАТ, УРАН САЙХАН, ОАК - БҮХ ТӨРЛИЙН ШУУД ДАМЖУУЛАЛТ - БҮХ ТӨРЛИЙН ШУУД ДАМЖУУЛАЛТ - БҮХ ТӨРЛИЙН ШУУД ДАМЖУУЛАЛТ - БҮХ ТӨРЛИЙН ШУУД ДАМЖУУЛАЛТ - БҮХ ТӨРЛИЙН ШУУД ДАМЖУУЛАЛТ	
1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго	
Япон маягийн менежментийг судлах, компаниудын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцах, туршлага судлах, хүний нөөцийн бодлого, компанийн тогтвортой хөгжил, дэлгүүрийн үйл ажиллагаатай танилцах, Hikkei Messe, FoodEx үзэсгэлэнтэй танилцах зорилготой явсан .	
2. Суралцсан зүйл	
- Японы менежмент, түүний онцлог - Япон компанийн философи - Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, процесс,	

4. Орчин үеийн тээвэр логистикийн систем, үйл ажиллагаа, чиг хандлага
5. 5S, 5W аргачлал
6. Хүний нөөцийн бодлого
7. Орчин үеийн дэлгүүрийн бодлого
8. Компанийн урт хугацааны тогтвортой хөгжил
9. Үзэсгэлэнд оролцох ойлголт гэх мэт

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

1. Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлнэ. Өөрөөр хэлбэл хүнээсээ эхэлнэ. Үзсэн суралцсан зүйлсээрээ сургалт орно.
2. 5S, 5W нэвтрүүлж ажиллана
3. МЭБ хурал дээр шаардлагатай АБТ-ыг нэг нэгээр нь шинэчлэх гэх зэрэг ажлуудыг төлөвлөсөн

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

1. Хувь хүнийхээ хувьд бүгдийг зэрэг хийх гээд тэрэндээ стрессдээд, түүнийгээ доод албан тушаалтнуудад буруу илэрхийлэх, түүнээс үүдээд хоорондоо ойлголцохгүй байх тохиолдол мэр сэр гардаг. Эхлээд өөрөөсөө эхлэх, маш сайн дараалалтай, төлөвлөгөөгөө нарийн гаргаж ажиллаж байх
2. Үйл ажиллагаагаа хүн бүрт ойлгомжтой байхаар хийх, 5S, 5W аргыг өөрийн үйл ажиллагааныхаа онцлогт тохируулаад хийгээд ашиглах

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

1. Энэ Япон дахь дадлага сургалтад хамрагдсанаар маш их зүйлийг ойлгож, өөрчилж чадна
2. Сурахад хэзээ ч оройтдоггүй юм шүү
3. Сурсан зүйлээ хэрэгжүүлээд яваарай

Нэр:

Э. Энхцэцэг

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2025

Анги:

Удирдлагын анги



Ажиллаж буй байгууллагын нэр	“Хасу Мод” ХХК
Албан тушаал	Захирал
Байгуулагдсан он	2010.04.08
Үйл ажиллагааны чиглэл	Гадаад худалдаа, мод үржүүлэг, цэцэрлэгжүүлэлт, нөхөн сэргээлт
Нийт ажилтны тоо	Үндсэн-5, гэрээт цагийн ажилтан-10-30
Компанийн товч танилцуулга	
Манай компани Сонгино хайрхан дүүргийн 21-р хороо Таширын хөндий соёндойн аманд 12 га талбайд мод үржүүлэг, 1 наст мандлын цэцэг, сургалт, хүнсний ногоо чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд : 8-10 төрлийн мод бут сөөг үрээр болон тарьц, харандаагаар нийт одоогийн байдлаар 500.000-550.000 ш үр үрсэлгээ суулгац тарьсан байна. Мөн 2025 онд 1 наст мандлын 8 нэр төрөл цэцэг 110.000 ширхэг үрсэлгээ хийгдэж байна. өөрийн талбай дээр 2-3 нэр төрлийн эмийн ургамлын судалгаа шинжилгээний ажил хийгдэж байна. Мөн компани болон хувь хүмүүсийн захиалгаар гадна тохижилт, ногоон байгууламжийн ажлыг чанар, стандартын өндөр түвшинд хийж гүйцэтгэж байна. Жишээ нь: арцат вилла, great stone, чулуут скай, залаат-2 зэрэг томоохон төслүүд дээр ногоон байгууламж, ландшафтын чиглэлээр амжилттай ажилласан. Зарим төслүүд нь үргэлжлээд явж байна.	
1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго	
- Foodex үзэсгэлэн худалдаанд оролцох - тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон сав баглаа боодол судлах - компаниуд хэрхэн яаж оролцож байгаа талаар судалгаа хийх	
2. Суралцсан зүйл	
Маш их зүйлийг суралцаад буцсандаа баяртай байна. Япон орны соёлтой танилцлаа. Мэддэг хэрнээ ажлын ачааллаас болоод ердөө хэрэгжүүлж чаддаггүй байсан 5S-ийг Ёшино Дэнгёо ХК-аас, 5W –Хитачи орон нутгийн аж үйлдвэрлэлийг дэмжих төвийн	

бүртгэлийн зөвлөх Күросү Ёшимицү болон бусад бүхий л очсон газраасаа суралцаж авлаа.

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

Хамгийн түрүүнд 5S-ийг хэрэгжүүлж эхэлнэ.

2-рт ажилчдадаа тогтвортой хөгжлийг бий болгохын тулд цаашид сургалт зохион байгуулах

3-рт ажилчдын идэвх оролцоог нэмэгдүүлэхийн тулд тэд нартаа чиглэсэн арга хэмжээнүүдийг шат дараалан хэрэгжүүлэх

4-рт инновац нэвтрүүлэх

5-рт техник тоног төхөөрөмжөө сайжруулах

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

Тогтвортой ногоон хөгжлийг дэмжиж, байгаль орчинд ээлтэй инновацын шийдлүүдийг бий болгон, хүн төрөлхтний амьдрах орчныг сайжруулан, эрүүл аюулгүй, хариуцлагатай ирээдүйг бүтээхэд хувь нэмрээ оруулна. Монгол улсдаа болон гадны улс оронд цэвэр эко эрүүл хүнсний ногоо болон эмийн ургамлыг ургамлаар болон эцсийн бүтээгдэхүүн болгон худалдаалахад чиглэж байна.

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Талархал илэрхийлэхийг хүслээ.

Япон дахь Жайка олон улсын төв болон Монгол японы төв, МУИС болон бүхий л сургагч багш, орчуулагч нартаа баярласан талархсанаа илэрхийлмээр байна. Цаашдын хамтын ажиллагаагаа улам өргөн дэлгэрүүлээсэй. Та бүхний хийж байгаа энэ сайн үйлсэд тань өндрөөс өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Нэр: М.Эрдэнэ-Оюун

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2019-2020

Анги: Удирдлагын анги



Ажиллаж буй байгууллагын нэр	“Жүр үр” ХХК Эрдэнэт салбар
Албан тушаал	Салбарын захирал
Байгуулагдсан он	2006 он /Эрдэнэт салбар/
Үйл ажиллагааны чиглэл	Бялуу, талх, нарийн боов
Нийт ажилтны тоо	95

Компанийн товч танилцуулга

Эрхэм зорилго: ДЭЛХИЙН СТАНДАРТАД НИЙЦСЭН ЧАНАР, ТААШААГДСАН АМТААР ДАМЖУУЛАН ХЭРЭГЛЭГЧДЭДЭЭ АЗ ЖАРГАЛЫГ ТҮГЭЭНЭ.

Алсын хараа: ДЭЛХИЙД ӨРСӨЛДӨХ БРЭНДИЙГ БҮТЭЭНЭ.

“Жүр үр” ХХК нь анх 1998 онд байгуулагдсан ба бялуу, нарийн боовны чиглэлээр тасралтгүй 26 жил үйл ажиллагаагаа явуулж буй Монголын топ компаниудын нэг билээ. Хамгийн сүүлийн байдлаар Монгол улсын 2024 оны ТОП-100 компанийн 34-р байрт жагссан нь Хэрэглэгчийн тэргүүн сонголт байж, дэлхийн чанар стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулдгийн илрэл юм.

2006 онд орон нутгийн анхны салбараа Эрдэнэт хотод байгуулсан бөгөөд Орхон, Булган, Хөвсгөл аймгуудын иргэдэд бялуу, бэйкэри төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн борлуулж байна. Одоогийн байдлаар 95 ажилтан, стандартын шаардлага хангасан агуулахууд, үйлдвэр, түгээлтийн багтай, ая тухтай суух үйлчилгээ бүхий худалдааны 4 салбартай үйл ажиллагаагаа явуулдаг.

1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

- Дэлхийн хүнсний зах зээлийн чиг хандлагыг судлах, шинэ шилдэг туршлага судлах
- Хүнсний үйлдвэрлэл болон худалдааны салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийг хөнгөвчлөх тоног төхөөрөмж, ажлын багаж хэрэгслийг судлах, энэ асуудлыг шийдвэрлэж буй Япон менежментийг судлах, компанидаа нэвтрүүлэх дэлхийн хүнсний зах зээлийн чиг хандлагыг судлах, шинэ шилдэг туршлага судлах

2. Суралцсан зүйл

- Бусад хүмүүсийн хувийн орон зайг хүндэтгэдэг, дэг журмыг чандлан сахидаг
- Ямар ч зүйлийг алдаагүй болтол сайжруулдаг, сайжруулалтыг тасралтгүй хийдэг
- Өөрийн хариуцан хийх ажлыг маш хариуцлагатайгаар үнэн шударгаар хийдэг.
- Япон менежментийн хамгийн чухал нөөц нь ажиллах хүч буюу ажилтан, тэднийг хэрхэн идэвхжүүлэх, тогтвортой ажиллуулах өөр өөрийн гэсэн онцлог аргатай.
- 5S аргыг ашиглаж байгаа байдал, үр дүнгээ тайлагнаж буй байдал, хэрхэн урт хугацаанд үр дүнтэйгээр үргэлжлүүлж байгаа
- Сургалт, уулзалтыг төлөвлөх, бизнесийн хамтрал үүсгэхэд анхаарах зүйлс, япон бизнесменүүдийг философи
- FOODEX үзэсгэлэнгээс Япон улсын төдийгүй орон орны хүнсний бүтээгдэхүүний харьцуулсан судалгааг 1 дороос хийн, хөгжлийг харьцуулан харсан
- Үйлдвэрт зочид хүлээн авах, үйлдвэрийн танилцуулга хийх, үйлдвэрийн процесстой танилцуулах сонирхолтой аяллын хөтөлбөртэй танилцсан
- Хүний оролцоог багасгаж мэдээллийн технологийн дэвшилтэд тоног төхөөрөмжийг ашиглах нь хүний нөөцийн хомсдолыг шийдэх арга юм.
- Японы төрөл бүрийн том, жижиг дэлгүүр, брэндүүдийн үндсэн философи, дэлгүүрийн менежмент, онцлогтой танилцсан.

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

- 5S хөдөлгөөнийг өрнүүлэхээр нийт ажилтнуудаа 8 багт хуваан 2025.04.01-ний өдрөөс эхлэн төлөвлөгөө гарган ажиллахаар болсон.
- Сургалтын хөтөлбөрийг урьдчилан гаргаж /сургалттай холбоотой бүх мэдээллийг багтаасан/ эхэлж байна.
- FOODEX-2025 үзэсгэлэнгээс судалсан BLACK SEASAME дээжийг туршиж байна. Технологийн багийн туршилт амжилттай болбол энэхүү түүхий эд материалыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн шинэ төрлийг бүтээгдэхүүн үйлдвэрлэх, байгалийн гаралтай органик будаг болгон ашиглах боломжтой гэж үзэж байгаа.
- Кайзен хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгасан.

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

- Байгаль орчноо хамгаалах, хог хаягдлаа ангилан ялгах, дахин боловсруулах ажлыг идэвхжүүлэх
- Дахин боловсруулсан хаягдлыг ашиглахыг уриалах

- Ажлын байран дээр дасгал хөдөлгөөн хийх хөдөлгөөн өрнүүлэх, ингэснээр хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэх, энгийн болон мэргэжлээс шалтгаалах өвчлөл буурах ач тустайг ажил олгогч, ажилтнуудад ойлгуулах, сурталчлах

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Тасралтгүй сайжруулалт, жижиг жижиг өөрчлөлтүүд нь амжилтын үндэс болохыг алхам тутмаасаа олж харах тул сониуч зангаар бүх зүйлийг харахыг хичээгээрэй, сургалтын хөтөлбөрт ороогүй маш олон зүйлийг анзаарах болно.
- Олдож байгаа чөлөөт цагаа бүрэн ашиглаж гадуур их яваарай, олон хүнтэй харилцаж соёлоос нь илүү их судлаарай, ингэхийн тулд биед эвтэйхэн дулаан хувцас, гутал бэлдэж очоорой.

Нэр:

О.Эрхэмбаяр

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2024

Анги:

Менежерийн анги



Ажиллаж буй байгууллагын нэр	Диасис Монголиа ХХК
Албан тушаал	Менежер
Байгуулагдсан он	2007
Үйл ажиллагааны чиглэл	Эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, эм, биологийн бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, ханган нийлүүлэх, импортлох
Нийт ажилтны тоо	15

Компанийн товч танилцуулга

Анх, Диасис Монголиа ХХК нь 2007 онд УКТЭ-ийн Нэгдсэн лабораторит биохимийн хагас автомат анализатор бэлэглэн лабораторийн салбарт ажиллаж эхэлсэн. 2011 оноос “Эмнэлгийн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, ханган нийлүүлэх, импортлох”, 2022 оноос “Эм, Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх” эрх бүхий компани болж өргөжсөн.

ХБНГУ-ын Диасис Диагностик Системс (Diasys diagnostic systems GmbH)



2007 оноос албан ёсоор дистрибьютор болж урвалж, биохимийн анализатор оруулж ирэн Монголын зах зээлд нийлүүлж байна. Одоогоор 70 гаран улсын болон хувийн хэвшлийн эмнэлэг, клиник эмнэл зүйн лабораторуудтай харилцан ажилладаг.

Манай байгуулга нь дараах үндсэн чиглэлүүдтэй:

- Урвалж, оношлуур ханган нийлүүлэх
- Эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх
- Лабораторийн анализатор, тоног төхөөрөмж ханган нийлүүлэх
- Эм импортлох ханган нийлүүлэх
- БИБ импортлох ханган нийлүүлэх
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ үзүүлдэг.

1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

- Менежерийн ангид үзсэн зүйлсээ орчинд очиж харах судлах.
- Хүний нөөцийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх.
- Хэрхэн жижиг орон зайд үйлдвэржилтийг шийдэх арга зам олох.
- Японы компаниудын менежментийн туршлагаас суралцах
- 5S,5W тогтолцоог хэрхэн үр дүнтэй нэвтрүүлж буй сайн туршлагаас суралцах

2. Суралцсан зүйл

- 5S хөтөлбөрөөс өөрт тохирох хөтөлбөрийг бий болгох, стратеги боловсруулах
- Эмх цэгцтэй, дэг журамтай, сэтгэлээсээ хандаж ажиллах нь бүтээгдэхүүний чанарт нөлөөлнө. Чанартай бүтээгдэхүүн чинь зах зээлд эзлэх байр суурийг чинь тогтоох болно.



- Тогтвортой хөгжлийн гол нууц нь сэтгэлээсээ ханд, цаг үргэлж суралц, тууштай хөдөлмөрлө, үргэлж инээмсэглэ тэгж чадвал амжилт аз чамайг дагах болно.
- Одооноос бүгдээрээ үрчийтлээ инээцгээ хэхэ.



3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

- 5S, 5W хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Ажилчдын ур чадварыг дээшлүүлэх, сургалт зохион байгуулах,
- Ажлын орчинд амрах хэсэг чөлөөт цагаагаа өнгөрөөх хэсгийг бий болгох ингэснээр ажилтнууд тогтвортой үр бүтээлтэй, сэтгэл хангалуун ажиллаа хийх, мэргэжилдээ улам дуртай болох.

- Үйлдвэрийн орчинг эрүүл аюулгүй, стандартад нийцсэн, хүний хөдөлмөрийг хөнгөвчилсөн байдлаар зохион байгуулж бий болгох.

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

- 5S дараах 3н S-ийг хэрэгжүүлэх үүнд: Цэгцлэх, Эгнүүлэх, Хэвшүүлэх
- Ур чадварыг сайжруулах, стандарт дүрэм журмыг мөрдүүлэх, дадал болгох.
- Менежер болон инженерүүдийг энэхүү дадлага сургалтанд хамруулах.

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Чиглүүлэх сургалт хамгийн чухал шүү үл ойшоож болохгүй, сургалтаа сайтар анхаарч авсан бол очсоны дараа бэрхшээл гарахгүй.
- Цаг сайн баримтал, Зорилгоо сайн тодорхойл
- Сургалтандаа идэвхитэй оролцох
- Бизнесийн хамтрагч болох хүнтэйгээ таарч болзошгүй тул өгөх гарын бэлэг авч яваарай. Учир нь анхны сэтгэгдэл маш чухал учир.
- Нэмж хэлхэд та Монгол улсын хилийн дээс алхаад л нэрээрээ биш Монгол хүн гэж бусдад харагддаг, нэрлэгддэг. Иймд хэлэх үг хийх үйлдлээ сайтар бодох хэрэгтэй шүү.

Амжилт хүсье!

Нэр: Б.Даваасүрэн



Ажиллаж буй байгууллагын нэр	Монгол Улсын Их Сургууль
Албан тушаал	Төлөвлөлт, Хөрөнгө оруулалт эрхэлсэн проректор, профессор
Байгуулагдсан он	1942
Үйл ажиллагааны чиглэл	Дээд боловсролын байгууллага
Нийт ажилтны тоо	1600
Компанийн товч танилцуулга	
Монгол Улсын Их Сургууль (товчлол МУИС) нь 1942 оны 10 сарын 05 өдөр байгуулагдсан, Монгол Улсын ууган их сургууль. Бүрэлдэхүүн 7 сургууль, орон нутаг дахь харьяаллын 3 салбар сургууль, үндэсний статустай 3 хүрээлэн, судалгааны бусад нэгжүүдтэй. Өнөөгийн байдлаар 1600 багш, ажилтан, 23604 суралцагчтай, бакалаврын 168, магистрын 174, докторын 52 хөтөлбөрөөр сургалтын үйл ажиллагаа эрхэлж байна. Эрдмийн зэрэгтэй багш нарын нийт багшид эзлэх хувь 59.7, гадаад багшийн нийт багшид эзлэх хувь 3 болно. Нийт суралцагчийн 71.7% нь бакалаврын, 28.3% нь ахисан түвшинд суралцдаг. МУИС-д гадаадын 17 улсын 316 иргэн бакалавр, магистр, доктор, монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт суралцаж байгаа бөгөөд үндэсний хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн нийт хөтөлбөрт эзлэх хувь 18.2%.	
1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго	
Орчин үеийн логистикийн систем, чанарын удирдлага, хэрэглэгчээ эрхэмлэсэн менежмент, үйлдвэрлэлийн процессын зохион байгуулалт зэрэг бизнесийн арга зүй, аргачлалыг практикт хэрхэн амжилттай хэрэгжиж буйг судлан, МУИС-ийн сургалт, судалгааны ажлыг баяжуулан, олон улсын чанартай, сайн туршлагыг хэрэгжүүлэх зорилготойгоор хамрагдсан.	
2. Суралцсан зүйл	
Логистик ба менежмент: KANTO, SEINO, AERO NEXT компаниудын жишээгээр логистикийн ухаалаг шийдлүүд, автоматжуулалт, нэгдсэн удирдлагын тогтолцоо.	

- **Хэрэглэгчээ эрхэмлэсэн менежмент:** MEG MILK компанийн үйлдвэрлэлийн процессын хялбарчлал, түүнийг хэрхэн удирдан зохион байгуулж байгаа талаар маркетингийн эвент, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад суурилсан менежмент.
- **Чанарын удирдлага:** HITACHI компанийн чанарын удирдлагыг хэрэгжүүлэхийн ач холбогдол, ISO стандартууд, ЯАГААД? аргачлал.
- **Компанийн соёл ба жижиг бизнес:** Yoshino Dengyo-ийн 5S хэрэгжилт, FUEKI SHOYU компанийн уламжлалт философи, компанийн соёл, бизнесийн тогтвортой загвар.
- **Жижиглэн худалдаа:** MUJI компанийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт, түүхий эдийн эрэл хайгуул, STP сегментчилэл дээр суурилсан маркетинг.
- **B2B арга хэмжээ:** Үзэсгэлэнгийн зохион байгуулалт, маркетингийн харилцааны ур чадвар.
- **Нийгмийн хариуцлага ба SDG:** Японы байгууллагуудын тогтвортой хөгжлийн зорилтуудыг практикт хэрхэн хэрэгжүүлж байгааг судалсан.
- **Үзэсгэлэн, арга хэмжээ:** Үзэсгэлэн, арга хэмжээтэй танилцсанаар бизнесийн харилцааны ур чадварт суралцсанаас гадна үзэсгэлэнд танилцуулах, бүтээгдэхүүний онцлог, түүнийг хэрхэн таниулан сурталчлах арга болон бүтээгдэхүүний үнэ цэнийг хэрхэн мэдрүүлэх аргыг бодит бизнес бий болгох, үр дүн бий болгох гэх мэтээр бизнесийн сургалтаар олж авсан онолын мэдлэгийг практикт биечлэн баталгаажуулсан.

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

- Байгууллагад чанарын удирдлагын “ЯАГААД?” аргачлалыг нэвтрүүлэн асуудлыг шийдвэрлэх тогтолцоотой болох
- 5S системийг туршиж хэрэгжүүлэхийг зорих
- Бизнесийн сургалтын хөтөлбөрт практикт суурилсан сургалтын хэлбэрүүдийг нэмэгдүүлэх
- Сургалтад японы компаниудын сайн жишээ, кейсүүдийг ашиглах
- МЯТ-ийн бизнесийн сургалтын хөтөлбөрийн шинэчлэлтэд оролцох.

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

- Чанарын удирдлага
- Хэрэглэгч төвтэй менежмент
- 5S зарчмуудыг байгууллагад нэвтрүүлэх
- МЯТ-ийн бизнесийн сургалтын хөтөлбөрийн агуулгыг сайжруулах, япон дахь дадлага сургалттай уялдуулах
- Дадлага сургалтад хамрагдах оролцогчдын тоог нэмэгдүүлэх
- Сургалтын үр дүнг талуудад сурталчлах.

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Сургалтын зорилго, хөтөлбөртэй урьдчилан сайтар танилцсан байх.
- Хөтөлбөрт тусгагдсан сургалтын агуулгыг онолын хүрээнд судалсан байх.
- Сургалтаар юуг мэдэх хувийн төлөвлөгөөгөө гаргасан байх.

Үр өгөөж өндөр чухал ач холбогдол бүхий сургалтыг зохион байгуулж, санхүүжүүлсэн Японы ард түмэнд маш их баярлалаа.

Нэр: Б.Батболд



Ажиллаж буй байгууллагын нэр	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газар
Албан тушаал	Мэдээллийн технологи, зах зээл борлуулалтын хэлтсийн дарга
Байгуулагдсан он	2020
Үйл ажиллагааны чиглэл	Төрийн байгууллага
Нийт ажилтны тоо	51
Компанийн товч танилцуулга	
Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн ажлын албыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газартай нэгтгэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Жижиг, дунд үйлдвэрийн газар” байгуулагдсан. Тус агентлаг нь УИХ, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны бодлоготой уялдуулан салбарын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах, судалгаа, шинжилгээ хийх, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд ажлын байр бий болгох, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, сургалт арга зүйгээр хангах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, инновацид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг кластераар хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг зүй зохистой удирдан, зохион байгуулах, зарцуулах, үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх, гадаадын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Манай байгууллага нь Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршооны салбарыг эрчимтэй хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, үндэсний үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилтийг хангах, хөнгөлөлттэй зээл, татаас олгох, улмаар нийгэм, эдийн засагт жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарын эзлэх байр суурийг бэхжүүлэх, тэдгээрийн хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлж, төрийн дэмжлэг үзүүлэх, тэдний эрх ашигт нийцсэн бизнесийн таатай орчныг бүрдүүлэх Эрхэм зорилготой Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг юм.	

1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго
☐ Япон маягийн менежментийн хэрэгжилт ☐ SDG бүх компани хэрэгжүүлж байна. ☐ Японы ард түмний хүний төлөөх чин сэтгэл, хөдөлмөрч зан чанар, үнэнч тууштай байдал.
2. Суралцсан зүйл
☐ B2B уулзалтад хэрхэн бэлтгэх, оролцох талаар сурсан. ☐ Бизнесийн сургалтаар олж авсан онолын мэдлэгийг практикт биечлэн баталгаажуулсан. ☐ Бизнесийн харилцааны ур чадварт суралцсан ☐ Үзэсгэлэнгийн зохион байгуулалт, оролцогчид хэрхэн бэлтгэл хангах талаар ☐ Үзэсгэлэнд танилцуулах бүтээгдэхүүний онцлог, түүнийг хэрхэн таниулан сурталчлах арга ☐ Бүтээгдэхүүний үнэ цэнийг хэрхэн мэдрүүлэх арга ☐ Бодит бизнес бий болгох, үр дүн
3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө
☐ Япон маягийн менежментийн хэрэгжилт ☐ SDG бүх компани хэрэгжүүлж байна. ☐ Японы ард түмний хүний төлөөх чин сэтгэл, хөдөлмөрч зан чанар, үнэнч тууштай байдал.
4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)
☐ Дадлага сургалтад хамрагдах оролцогчдыг нэмэгдүүлэх, ☐ МЯТ-ийн Бизнесийн үндсэн сургалтын хөтөлбөрийн агуулгыг сайжруулах, япон дахь дадлага сургалттай уялдуулах, B2B дэх удирдлага, брэндийн удирдлага, экспортын маркетинг... ☐ Үзэсгэлэн, арга хэмжээнд оролцох бэлтгэлээ хэрхэн хангах талаарх сургалт
5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл
☐ Бизнесийн сургалтаар олж авсан онолын мэдлэгийг практикт биечлэн баталгаажуулах нь чухал учраас төлөвлөлтийг сайн хийж Япон улсад очих ☐ Бизнесийн харилцааны ур чадварт суралцах бэлтгэлийг хангаж очих

Нэр:

Н.Батдэлгэр



Ажиллаж буй байгууллагын нэр	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв
Албан тушаал	Ерөнхий менежер
Байгуулагдсан он	2002
Үйл ажиллагааны чиглэл	Боловсрол, соёлын үйл ажиллагаа
Нийт ажилтны тоо	31

Компанийн товч танилцуулга

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь Монголын зах зээлийн эдийн засагт хувь нэмэр оруулахуйц хүний нөөцийг хөгжүүлэх

Монгол, Япон хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА), Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам болон МУИС-н

хамтарсан төсөл хэлбэрээр 2002 оноос үйл ажиллагаагаа эхлүүлэн өдгөө 23 дахь жилдээ үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна. Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх сургалт, япон хэлний боловсрол, соёлын үйл ажиллагаа, 2 орны бизнесийн хамтын ажиллагаа гэсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Мөн өнөөг хүртэл бий болгосон харилцаа холбоогоо үр дүнтэйгээр ашиглан Япон, Монголын бизнесийн гүүр болон ажиллахыг зорьж байна.



1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

Цаашид Монгол Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь бие даан япон дахь дадлага сургалт, FOODEX-тэй танилцах сургалтыг зохион байгуулахад шаардлагатай мэдээлэл цуглуулах, анхаарах асуудлуудыг тодорхойлох зорилгоор хамрагдсан.


- Урьдчилсан сургалтын үеэр анхаарах зүйлс,
- Япон дахь дадлага сургалтын үеийн анхаарах зүйлс
- Монголд ирсний дараах фоллов-апын үеэр анхаарах зүйлс

2. Суралцсан зүйл

Дараах зүйлсийг анзаарч, суралцлаа. Үүнд:

- Бизнесийн байгууллагууд хоорондын өрсөлдөөн ширүүсч, стратеги өөрчлөдөг байна.
- Байгууллага хоорондын хамтын нягт ажиллагаа (Хитаичи хотын засаг захиргааны нэгж)-ны үр дүнд гадаад зах зээлд гарах компаниудыг дэмжиж байна.
- Үзэсгэлэн яармагийн өндөр түвшний зохион байгуулалт
- Сургалтыг удирдан явуулахдаа, нэг чиглэлээс мэдээллээр бөмбөгдөх бус, харилцан яриа, анзаарал зэргээс суралцах агуулга хамгийн өндөр байгааг олж харсан. Нэг ижил зүйл харж байгаа ч, хүнээс хамаарч ялгаатай байдлаар өөрийн болгож, тухайн агуулгыг буцаагаад бусдад хуваалцахдаа ялгаатай өнцгөөс тайлбарладаг.

Хувийн хүлээлтийн хувьд энэ удаагийн япон дахь дадлага нь сургалт гэхээсээ илүүтэй, бизнес тур, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой байсан хэдий ч, хамт явсан захирал, менежерүүдээс авсан судалгааны үр дүн нь илүү сургалтын агуулга нь таалагдсан үр дүн гарсан.



3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

2026 онд төв бие дасаан байдлаар тухайн дадлага сургалтыг зохион байгуулсан тохиолдолд, нэг талаас сургалтын нийт зардлыг аль болох бага байлгах зорилгоор, мөн үр дүнг бууруулахгүй байх зорилгоор дараах хуваарийн дагуу сургалт (бизнес тур) зохион байгуулах нь оновчтой гэж үзэж байна.

Огноо	Очих газар	Тайлбар
Урьдчилсан сургалт		Урьдчилсан сургалт
2026.03.06 (Пүр)	Улаанбаатар→Нарита	Буудал ТИС*
2026.03.07 (Баа)	Никкей Мессе (Эргэн харах)	FOODEX-тэй танилцах
2026.03.08 (Бям)	Жижиглэн худалдааны дэлгүүр (Урьдчилсан сургалт)	бэлтгэл (Япон мэргэжилтэн Япон мэргэжилтэн)
2026.03.09 (Ням)	Бие даан суралцах өдөр	
2026.03.10 (Дав)	Компани, үйлдвэртэй танилцах (Япон маягийн менежмент, стратеги)	Жишээ: Фуэки цуу ХК Автобус түрээслэх
2026.03.11 (Мяг)	FOODEX-тэй танилцах, эргэн харах	
2026.03.12 (Лха)	FOODEX-тэй танилцах, хэлэлцээр хийх	Нэмэлт орчуулагч шаард
2026.03.13 (Пүр)	Бие даан суралцах өдөр, МОЈС ажилтан шаардлагатай тохиолдолд FOODEX-д ажиллах	
2026.03.14 (Баа)	Нарита→Улаанбаатар	** Сургалтанд оролцох үлдэх тохиолдолд?
Дараах сургалт	Бизнес аялалыг эргэн харах	

*JICA төвийг ашигласан тохиолдолд сургалтанд хамрагдагсах бүгд МОЈС үндсэн сургалт төгсөгч эсвэл үндэсний сургагч багш нар байх

**JICA сургалт биш учраас, үлдэнэ гэсэн хүсэлтийг хүлээн авах эсэхийг нягтлах

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

Бизнес тур хийж монголд ирсний дараа, хэрхэн хамтын ажиллагааг хангах, дэмжиж ажиллах талаар хийх ажлуудыг төлөвлөх шаардлага өндөр байна. Мөн сургалтын агуулгын хүрээнд, ялангуяа диверсификаци хийх тохиолдолд, гадаад зах зээл рүү чиглэх вэ гэсэн агуулгыг нэмж оруулахаар зорьж байна.

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Сургалтын өмнөх бэлтгэл ажлыг сайн хангах шаардлагатай. Бизнесийн үндсэн сургалтаар олж авсан агуулга болон дадлага сургалтад хамрагдахаас өмнөх бэлтгэл сургалтуудын уялдаа холбоог дахин нягтлах шаардлагатай. Мөн FOODEX зэрэг үзэсгэлэн яармагт оролцох гэж байгаа бол урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж байж оролцох шаардлагатай. Ялангуяа, тодорхой нэг хамтрагчтай уулзалт зохион байгуулах үедээ эсрэг талын мэдээлэлтэй урьдчилан танилцах, бэлтгэл ажлыг сайтар хангахыг зөвлөж байна.

Нэр:

Э.Эрдэнэцэцэг



Ажиллаж буй байгууллагын нэр	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв
Албан тушаал	Япон хэлний сургалтын тасгийн дарга
Байгуулагдсан он	2002
Үйл ажиллагааны чиглэл	Боловсрол, соёлын үйл ажиллагаа
Нийт ажилтны тоо	31

Байгууллагын товч танилцуулга

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь Монголын зах зээлийн эдийн засагт хувь нэмэр оруулахуйц хүний нөөцийг хөгжүүлэх, Монгол, Япон хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага /ЖАЙКА/, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам болон МУИС-ийн хамтарсан төсөл хэлбэрээр 2002 онд үйл ажиллагаагаа эхлүүлэн



эдүгээ 23 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. 2012 оноос япон хэлний боловсрол болон соёлын хамтын ажиллагааны чиглэлээр Японы засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Япон сантай хамтран ажиллаж байна.

Үйл ажиллагааны хүрээнд япон хэлний сургалтын үйл ажиллагаа, бизнес эрхлэгчдэд зориулсан сургалт семинарууд, монгол япон хүмүүсийн хоорондын харилцаа холбоо, харилцан ойлголцлыг бэхжүүлэхийн төлөөх төрөл бүрийн сургалт, соёлын арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна.

Цаашид ч Монгол улсын ирээдүйн хөгжилд хувь нэмэр оруулахуйц хүний нөөцийг бэлтгэж, Монгол, Япон хоёр улсыг холбогч гүүр болон ажиллах болно.

1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

- 1) Япон маягийн менежментийн талаарх ойлголтоо гүнзгийрүүлж, японы компаниудын менежментийн арга барил, туршлагаас суралцах.
- 2) Японы компаниудын хүний нөөцийн менежментийн сүүлийн үеийн чиг хандлага, ажилтнаа хэрхэн сургаж хөгжүүлж буй арга барилаас суралцах.
- 3) Японы компаниудын 5S тогтолцоог хэрэгжүүлж буй сайн туршлагаас суралцах.
- 4) Япон дахь дадлага сургалтаас олж авсан мэдлэг, мэдээллээ ажилдаа үр дүнтэй хэрэгжүүлэх.
- 5) Дараагийн дадлага сургалтыг төв бие даан зохион байгуулахад хэрэгцээт мэдээ мэдээллийг цуглуулах, суралцах.

2. Суралцсан зүйл

- 1) Компанийн соёл гэдэг бол зочноо угтаж, үдэж буй байдлаас эхэлдгийг зочлон очсон бүх компаниас мэдэрч суралцлаа. “Омотэнаши” буюу “Зочлох үйлчилгээний соёл”-ыг жижиг компани хэдий ч төгс хэрэгжүүлж буй бодит жишээг харлаа.
- 2) Компани урт удаан хугацаанд оршин тогтнох гол хүчин зүйл бол тухайн компанийн философид орших ба уг философийг бүх ажилтандаа ойлгуулах, компанийн алсын хараа, эрхэм зорилгыг ажилтан бүр ухамсарлан ажиллах ёстойг ойлгож авлаа.
- 3) Компанийн үнэт зүйл бол “ажилтан” бөгөөд ажилтнуудын эрүүл мэнд, улмаар ажилтнуудын гэр бүлийн эрүүл мэндийг эрхэмлэснээр, урт удаан хугацаанд тогтвор суурьшилтай амжилттай ажиллахад нөлөөлдгийг ойлголоо.
- 4) Ажилтнуудаас гарсан санал санаачилгыг сонсож, хэрэгжүүлж болохуйц санал санаачилгыг цаг тухайд нь дэмжсэнээр ажлын бүтээмж, ажилтнуудын урам зориг, ажилдаа хандах хандлага нэмэгддэгийг ойлголоо.
- 5) Ажилтанд чиглэсэн сургалт хөгжүүлэлт нь хувь хүний хөгжилд нөлөөлж, улмаар компани амжилттай ажиллахад нөлөөлдгийг ойлголоо.
- 6) Асуудлын үндсийг илрүүлэн арилгах “Яагаад, яагаад” шинжилгээний аргаас суралцлаа.
- 7) Ажлын байранд жижиг гэлтгүй байнгын хөгжүүлэлт сайжруулалт буюу “5S кайзэн”-г хийж дадахын үр дүнг харлаа.
- 8) Үйлдвэрлэлийн процессоо аялал жуулчлалын цэг, маркетингийн хэрэгсэл болгон үр дүнтэй ашиглаж байгааг харлаа.

3. Сургалтаар суралцсан зүйл, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө**4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсэж буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)**

- 1) Хамт олондоо энэ удаагийн дадлага сургалтаар олж авсан мэдээ мэдээлэл, суралцсан зүйлээ тайлагнах.
- 2) Байгууллагын шинэ ажилтны сургалтыг шинэчлэн хөгжүүлэхэд гар бие оролцон ажиллах.
- 3) “Study tour” сургалтын агуулгыг илүү баяжуулж, монгол орон, монгол соёл, зан заншил, монголын нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал, монголын бизнесийн орчин нөхцөл зэрэг агуулгаар зохион байгуулахад бэлдэх. “Монгол-Японы төвийн үйл ажиллагаатай танилцах тур” болгон хөгжүүлэхэд баг бүрдүүлэн ажиллах.
- 4) Япон дахь дадлага сургалтын өмнөх чиглүүлэх сургалтын агуулгад япон хэлний 1 удаагийн танилцуулах сургалт /мэндчилгээний үг хэллэг, өөрийгөө товч танилцуулахад хэрэглэгдэх үг хэллэг, худалдан авалт хийхэд шаардлагатай ойр зуурын үг хэллэг зэрэг/-ыг оруулж, дадлагад хамрагдаж буй хүмүүст япон соёлд илүү ойртох боломжийг олгох.
- 5) Хүний нөөцийг тогтвортой байлгах, ажилтнуудын өөрийгөө хөгжүүлэх хүсэл эрмэлзлийг дэмжих үүднээс байгууллагын дотоод сургалтууд болон бусад байгууллагын сургалтад хамрагдахад нь дэмжлэг үзүүлэх. Хамтдаа хөгжиж боловсроход чиглэсэн шинэ сургалтыг санаачлах, шаардлагатай тохиолдолд зочин багшаас сургалт авах боломжийг бий болгох.

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- 1) Цаг сайн баримтлах.
- 2) Хувийн бэлтгэлээ сайн хангаж, сургалтдаа идэвхтэй оролцох.
- 3) Сургалтын үеэр цаг тухай бүрд тэмдэглэл хөтөлж явах.
- 4) Сургалтын материал, компанийн танилцуулгатай компани дээр очихын өмнө урьдчилан танилцаж судалсан байх.
- 5) Сургалтаас олж авсан мэдлэг туршлага, сайн үр дүнг компанидаа шуурхай тайлагнаж, сургалтыг зохион байгуулах.
- 6) Сургалтын баг хамт олноос харилцан суралцах.